

**“ТЭН ХУН” ХХК**

**ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
НАРАНТОЛГОЙ УУРХАЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар  
2024**

АГУУЛГА

1. НАРАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	7
1.1. Түүхэн товчоо.....	10
1.2. Нарантолгойн алтны ордны геологийн бүтэц .....	11
1.3. Цаг уур, уур амьсгалын онцлог .....	12
1.4. Нарантолгойн уурхайн техник эдийн засгийн үндэслэл .....	13
1.5. Уурхайн гол барилга байгууламж .....	14
1.5.1. Далд уурхайн барилга байгууламж.....	15
1.5.2. Баяжуулах үйлдвэр .....	16
1.5.3. Хаягдлын далан.....	18
1.5.4. Цахилгаан эрчим хүчний хангамж.....	20
1.5.5. Усан хангамж .....	22
1.5.6. Химийн бодисын агуулах .....	23
1.5.7. Баяжуулах үйлдвэрийн лаборатори .....	24
1.5.8. Техникийн засвар үйлчилгээний барилга байгууламж.....	25
1.5.9. Тэсрэх материалын агуулах .....	26
1.5.10. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц (ШТС).....	27
1.6. “Тэн Хун” ХХК-ний байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд.....	28
1.6.1. “Тэн Хун” ХХК-ны эзэмшдэг тусгай зөвшөөрөл .....	28
1.6.2. Газар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ.....	28
1.6.3. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл.....	28
1.6.4. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлан .....	29
1.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нийт зардал.....	29
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО .....	29
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	30
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	30
3.2. Хөрс орчинд үзүүлэх нөлөөлөл .....	32
3.2.1. Хөрсний хүнд металлын шинжилгээ .....	33
3.3. Ургамал, амьтанд үзүүлэх нөлөөлөл.....	35
3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл .....	36
3.4.1. Далд уурхайн шүүрлийн усны судалгаа .....	36
3.4.2. Усны төлбөр, ус ашиглалтын байдал.....	37
3.4.3. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ болон дүгнэлт.....	38
3.4.4. Усны тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах, тоолуур баталгаажуулах.....	39
3.4.5. Сум, орон нутгийн булаг шандны эхийг сэргээн засварлах .....	42

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	45
4.1. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт .....	46
4.2. 2012-2024 оны хооронд тарьсан модны тайлан .....	50
4.3. Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт .....	55
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	55
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	55
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	55
7.1. Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ зарцуулалт.....	55
7.1.1. Химийн бодисын хадгалалт .....	55
7.1.2. Химийн бодисын тээвэрлэлт .....	56
7.1.3. Химийн бодисын хэрэглээ .....	57
7.1.4. Химийн бодис алдагдсанаас үүсэх нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж .....	57
7.2. Галын аюулгүй байдал .....	57
7.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал .....	61
7.4. Эрүүл мэндийн үзлэг .....	63
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	67
8.1. Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах .....	70
8.2. Хог хаягдлын цэвэрлэгээний бүсчлэлийн зураг боловсруулах .....	72
8.3. Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулах .....	73
8.4. Хог хаягдал цуглуулах тээвэрлэх гэрээ .....	73
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ .....	74
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	75
10.1. Үүрэг хариуцлага .....	76
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	78
11.1. Хөрсөн бүрхэвчийн мониторинг .....	78
11.2. Ургамлан нөмрөгийн мониторинг .....	85
11.3. Агаарын чанарын мониторинг .....	94
11.4. Усан орчны мониторинг .....	95
12. ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТУУД .....	98

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Нарантолгой уурхай .....	7
Зураг 2. Нарантолгойн уурхайн байршил .....	8
Зураг 3. Хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ (блок загварчлалаар, хойшоо харсан байдал).....	11
Зураг 4. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ .....	12
Зураг 5. Нарантолгойн алтын уурхайн захиргаа, ажилчдын байрны цогцолборын бүдүүвч зураг .....	14
Зураг 6. Далд уурхайн босоо ам.....	15
Зураг 7. Баяжуулах үйлдвэр .....	16
Зураг 8. Хаягдлын далан .....	18
Зураг 9. Хаягдлын далангийн схем .....	19
Зураг 10. Уурхайн дэд станц оролтын шугамын хүчин чадал (35000V).....	20
Зураг 11. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий байршил.....	21
Зураг 12. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем.....	21
Зураг 13. Ахуйн болон технологийн хэрэглээний гүний худаг .....	22
Зураг 14. Химийн бодисын агуулах .....	23
Зураг 15. Баяжуулах үйлдвэрийн лаборатори .....	24
Зураг 16. Техникийн засвар, үйлчилгээний барилга.....	25
Зураг 17. Тэсрэх материалын агуулах .....	26
Зураг 18. Шатахуун түгээх станц.....	27
Зураг 19. Агаарын чанарын хэмжилт .....	31
Зураг 20. Ургамлын зүйлүүдийн биомасс авч буй байдал .....	35
Зураг 21. Тоолуурын сүүлийн баталгаажуулалт-2024 .....	41
Зураг 22. “Хоолтын Амны” нойр булчирхайн рашааныг тохижуулахын өмнөх байдал.....	42
Зураг 23. “Хоолтын Амны” нойр булчирхайн рашааныг тохижуулсаны дараах байдал .....	43
Зураг 24. “Хоолтын Амны” ходоодны рашааныг тохижуулахын өмнөх байдал.....	43
Зураг 25. “Хоолтын Амны” ходоодны рашааныг тохижуулсаны дараах байдал .....	44
Зураг 26. Нарсны суулгац тарихын өмнөх бэлтгэл ажил .....	47
Зураг 27. Шан татсан байдал.....	47
Зураг 28. Мод тарьж буй байдал.....	48
Зураг 29. “Тэн Хун” ХХК-ны бяцхан ой хамгаалагч .....	48
Зураг 30. Мод тарихад оролцсон ажилтан, албан хаагчид .....	49
Зураг 31. Уурхайн хашаанд мод тарьж буй байдал .....	49
Зураг 32. Төв аймгийн БОАЖГ-ын шалгалт.....	51
Зураг 33. Эрдэнэтолгой ууланд ойжуулах ажлын шалгалтын явц .....	51



Зураг 34. Төв аймгийн Батсүмбэр сумын онцгой байдлын газрын хяналт шалгалт .....	58
Зураг 35. Галын аюулгүй байдал, Гамшгийн эрсдлийн сургалт .....	59
Зураг 36. Практик сургалт .....	59
Зураг 37. Галын сарааны өнгө үзэмж, бүрэн бүтэн байдлыг сэргээн засварлав.....	60
Зураг 38. Галын сарааны будгийн ажил .....	60
Зураг 39. Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад амжилттай оролцсон ажилтнууд.....	62
Зураг 40. Саармагжуулах бүтээгдэхүүн .....	63
Зураг 41. ХАБ сайн сахиагч ажилчид.....	63
Зураг 42. Витаминжуулалтын аян .....	64
Зураг 43. ХАБ-ын мэдлэг шалгах АХА тэмцээн .....	64
Зураг 44. Намрын галын аюулгүй байдлын сургалт .....	65
Зураг 45. Намрын галын аюулгүй байдлын практик сургалт .....	65
Зураг 47. Хог ангиалан ялгаж буй байдал.....	68
Зураг 48. Ажилчдад хог ангиалан ялгах талаар зөвлөгөө өгч буй байдал .....	69
Зураг 49. Ангиалан ялгах хогийн сав байршуулсан байдал.....	69
Зураг 50. Орчны хог орчны цэвэрлэгээ .....	70
Зураг 51. Орчны хог орчны цэвэрлэгээний өмнөх ба дараах байдал .....	70
Зураг 52. Салдагаас уурхай хүртэлх замын цэвэрлэгээ .....	71
Зураг 53. Хог хаягдлын цэвэрлэгээний өдөр .....	71
Зураг 54. Орчны хог хаягдлын бүсчлэлийн зураг .....	72
Зураг 55. БОМТБТ-г сумын ИТХ-ын танилцуулах үеийн зураг .....	75
Зураг 56. Хөрсний зүсэлтийн бичиглэл: Зүсэлт 1-Баяжуулах үйлдвэр.....	80
Зураг 57. Хөрсний зүсэлтийн бичиглэл: Зүсэлт 2-Уурхайн кемп.....	81
Зураг 58. Хөрсний зүсэлтийн бичиглэл: Зүсэлт 3-Хаягдлын далан .....	82
Зураг 59. Хөрсний зүсэлтийн бичиглэл: Зүсэлт 4-Талбайн гадна .....	83
Зураг 60. Хөрсний зүсэлтийн бичиглэл: Зүсэлт 5-Герман ам .....	84
Зураг 61. Баяжуулах үйлдвэр орчмын ургамлын бичиглэл.....	86
Зураг 62. Уурхайн кемп орчмын ургамлын бичиглэл .....	88
Зураг 63. Лицензийн талбайн гадны орчмын ургамлын бичиглэл .....	90
Зураг 64. Герман амны доод хэсгийн ургамлын бичиглэл.....	92
Зураг 65. Герман амны ургамлын бичиглэл .....	93

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. “Тэн Хун” ХХК-ийн мэдээлэл.....	9
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолууд .....	9
Хүснэгт 3. “Тэн Хун” ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд .....	28
Хүснэгт 4. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ.....	28
Хүснэгт 5. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл, хүчинтэй хугацаа.....	28
Хүснэгт 6. Хаягдлын далангийн шаврын химийн шинжилгээ .....	34
Хүснэгт 7. Хөрсний зүсэлтийн цэгүүдийн бичиглэлийн мэдээлэл .....	34
Хүснэгт 8. Усны гэрээ, дүгнэлтийн мэдээлэл.....	38
Хүснэгт 9. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-1 .....	39
Хүснэгт 10. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-2 .....	39
Хүснэгт 11. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-3 .....	40
Хүснэгт 12. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-4 .....	40
Хүснэгт 13. 2023, 2024 оны рашаан, булаг тохижуулахад орсон нийт зардал.....	44
Хүснэгт 14. Шимт хөрсний овоолгын химийн шинжилгээний дүн .....	45
Хүснэгт 15. Шимт хөрсний овоолгын физик-механикийн шинжилгээн дүн .....	46
Хүснэгт 16. 2012-2024 оноос хүртэл тарьсан модны тайлан .....	50
Хүснэгт 17. Тарьсан модны мэдээлэл .....	53
Хүснэгт 18. Хөрсний дээжинд задлан шинжилгээ хийсэн арга, нарийвчлал .....	78
Хүснэгт 19. Хөрсний зүсэлтийн цэгүүдийн бичиглэлийн мэдээлэл .....	79
Хүснэгт 20. Төслийн талбай орчмын агаарын чанар .....	94
Хүснэгт 21. Гал тогооны усны шинжилгээний дүн .....	95

### Диagramмын жагсаалт


Диagramм 1. 2020-2024 оны усны төлбөр төлөлтийн байдал.....	37
Диagramм 2. Хэсгүүдийн харьцаа .....	77

## 1. НАРАНТОЛГОЙН УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нарантолгой алтны үндсэн ордыг 1966-1970 онуудад Герман геологичид илрүүлж байсан бөгөөд 2013 онд нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж 2015 онд улсын нэгдсэн нөөцийн санд бүртгүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших 375.18 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-000713 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Нарантолгойн алтны үндсэн ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2037 он хүртэл хүчинтэй, АМТХуулийн дагуу 10 жилээр 2 удаа сунгагдах эрх нь нээлттэй. БНХАУ-аас 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд 2006 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийгдсэн.

БНХАУ-ын Янтай Тэн Хун компани нь 2004 оны 7 дугаар сард Монгол Улсад хөрөнгө оруулан Тэн Хун ХХК-ийг анх байгуулсан. Манай компани нийт 185 ажилчидтай үүнээс 25 ажилчин нь хятад 160-н монгол ажилчидтай болно. 2006 оноос эхлэн уг ордыг ашиглалтанд бэлтгэх зорилгоор далд уурхайн малгалт нэвтрэлтүүдийг хийх, хуучин малталтуудыг сэргээн засварлах, барилга байгууламжуудыг барих, дэд бүтцийг хөгжүүлэх, ордыг ашиглах эрхзүйн баримт бичгийг боловсруулж батлуулах зэрэг бэлтгэл ажлуудыг хийж улмаар 2010 оноос далд уурхайн ашиглалтыг эхлүүлсэн. Нийт ажилчид нь Үйлдвэр төлөвлөтийн хэлтэс, Дотоод хяналтын хэлтэс, Байгаль орчин хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтэс, Баяжуулах үйлдвэр, Санхүүгийн хэлтэс, Хангамжийн хэлтэс, Хүний нөөц захиргаа удирдалгын хэлтэс, Тоног төхөөрөмж засвар үйлчилгээний хэлтэс гэсэн 8-н хэлтэст хувиарлагдан ажилладаг.



Зураг 1. Нарантолгой уурхай


## Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

**Уурхай байршил:** “Тэн Хун” ХХК-ийн олборлолт явуулж буй “Нарантолгойн алтны үндсэн орд” нь Төв аймгийн Жаргалант суманд байрладаг аймгийн төвөөс 140 км, Улаанбаатар хотоос баруун хойш 130 км зайд байрладаг.

Төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд мал аж ахуй, газар тариалан голлон эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд алт, нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхлэх болсон бөгөөд газар тариалан хүнсний ногоо, фермерын аж ахуй хурдацтайгаар хөгжиж байгаа дэд бүтэц сайн хөгжсөн төвийн нутагт байрлаж байгаа болно.

Сүхбаатар-Улаанбаатар хотыг холбосон хатуу хучилттай засмал зам ордоос зүүн тийш 12 км-н зайтай өнгөрнө. 2013 онд энэ замаас Жаргалант сум хүртэл хатуу хучилттай засмал зам тавигдсан бөгөөд энэ замаас төслийн талбай хүртэл 7 км сайжруулсан шороон замтай. Нарантолгойн ордоос зүүн хойд зүгт 52 км-т Дархан-Улаанбаатарын төмөр зам өнгөрдөг.

Нарантолгойн ордоос урагш 2-3 км зайд Борнуур, Цагаан булагийн 110 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Борнуур, Угтаалыг холбосон 35 кВ-ын цахилгаан шугам зэрэгцэн өнгөрнө. Нарантолгойн уурхай нь Борнуур-Жаргалантын 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугамаас тэжээгдэж байна.



Зураг 2. Нарантолгойн уурхайн байршил



**Ангилал:** Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төсөл /Далд аргаар ашиглах уурхайн ТЭЗҮ-ийг боловсруусан/

**Төслийн зорилго, ач холбогдол:** Нарантолгойн алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар, улс орон нутгийн экспортын орлого нэмэгдэхээс гадна уурхай болон уурхайг дагалдан тухайн бүс нутагт ханган нийлүүлэгч, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих, аж ахуй нэгжүүд шинээр байгуулагдаж, олон тооны ажлын байр бий болж, орон нутагт ажил эрхлэлт нэмэгдэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, шинээр хүн амын төвлөрөл бий болох зэрэг олон эерэг нөхцөл бүрдэх болно.

Хүснэгт 1. “Тэн Хун” ХХК-ийн мэдээлэл

Нарантолгой төслийг хэрэгжүүлэгч аж ахуй нэгж	Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Нарантолгой ХХК-ийн хаяг, байршил
“Тэн Хун” ХХК	9019016020	Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах “Нарантолгойн алтны үндсэн орд”-ын төсөл	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Богд-Ар хороолол, 2а байр 14 тоот

**Ажиллах хүчний тухай:** Нарантолгойн алтны уурхай нь жилд 81000 тн хүдэр олборлох хүчин чадалтай бөгөөд төслийн ТЭЗҮ-д баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг тооцохдоо далд уурхайн хүчин чадал, захиалагчийн хүсэлт, уурхайн хэтийн төлөв, бүс нутгийн цаг уурын нөхцөл зэргийг харгалзан үзэж 12 тн/цаг хүчин чадалтай байхаар тооцсон байна. Нарантолгойн уурхай нь жилийн турш тогтмол үйл ажиллагаатай байх бөгөөд олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн хүчин чадлаараа ажиллаж жигдэрсэн тохиолдолд 206 орчим үндсэн ажилтан /уурхайн удирдлага, ИТА-10%, тусгай мэргэжлийн ажилтан-70%, бусад-20%, 80 орчим түр хугацааны гэрээт ажилтан байхаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолууд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	105	55	51.11	48	33	53.88
2	105	55	51.11	48	34	29.87
3	105	56	16.12	48	34	29.87
4	105	56	16.12	48	35	10.88
5	105	55	6.12	48	35	10.88
6	105	55	6.12	48	34	29.87
7	105	54	26.12	48	34	29.87
8	105	54	26.12	48	33	53.88
9	105	55	51.11	48	33	53.88

### 1.1. Түүхэн товчоо

**Уурхай эхэлсэн огноо:** Нарантолгойн алтны үндсэн орд нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт Улаанбаатар-Дархан-Сэлэнгийн засмал замын баруун хэсэгт 20 км орчим зайд оршино. Уг орд нь кварц-бага сульфид-алтны орд бөгөөд үндсэн 1 судал, түүнтэй зэрэгцээ 2 жижиг судлын хэсэг 3 биетээс тогтоно.

Нарантолгойн орд нь босоо-налуу уналттай урт сунасан судлын төрлийн орд бөгөөд далд аргаар ашиглалт явагдаж байгаа орд юм.

1966-1968 онд явуулсан нарийвчилсан эрлийн ажлаар Хэнкель нарын геологиуд (1968) Нарантолгойн орчимд тархсан кварцын судлуудыг гадаргуугаас нь дээжлэн кварцын судлын төрлүүдийг тогтоон, алттай кварцын судлуудыг ялгасан. 1968-1970 онд явуулсан хайгуулын ажлын дүнд Хэнель нар (1971) Нарантолгойн алттай кварцын судлуудыг гадаргуугаас нь сувгаар нээж ховилон сорьцлолт хийсэн ба Үндсэн, Зэрэгцээ судлуудад өрмийн цооног болон далд малталтуудаар хайгуул хийж алт, мөнгөний нөөцийг тооцоолсон.

Нарантолгойн ордын ТЭЗҮ-ийг анх 2009 онд “Уул уурхайн хүрээлэн” гүйцэтгэж байсан бөгөөд ТЭЗҮ-ийн тодотголыг 2015 онд “Абсолютмайнинг” ХХК гүйцэтгэсэн байна.

Уг ТЭЗҮ-ийн тодотгол-1-ийг боловсруулахдаа ордыг 9 жилийн хугацаанд далд уурхайн аргаар, шпурын цэнэгээр тэсэлж, хоршоолон нураан олборлох системээр үргэлжлүүлэн ашиглана.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг боловсруулах ажлыг Геологи, Уул уурхайн зөвлөх үйлчилгээ, зураг төслийн “Гоулдмэн Прожект” ХХК-ийн инженерүүд, МУ-ын зөвлөх инженер С. Ичинноров зөвлөснөөр холбогдох хууль дүрэм, журмын хүрэн хийж гүйцэтгэсэн.

1982 онд Бороогийн алтны ордын хайгуулын ажлыг хийсэн Монгол-Германы геологичид Нарантолгойн ордын нөөцийг дахин тооцоолсон. 1997 онд Нарантолгойн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон ч ашиглалтанд бэлтгэж амжилгүй байтал “Нинжа” нар Германиудын малтсан хэвтээ амыг дур мэдэн орж штольнийн түвшин, түүнээс дээш болон доош орших блокуудад олборлолт хийсэн байгаа юм. 2004 оны 7 дугаар сард БНХАУ-ын Янтай Тэн Хун компани Монгол Улсад хөрөнгө оруулан “Тэн Хун” ХХК-ийг анх байгуулсан.


Алтны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар “Тэн Хун” ХХК нь “Восток-Эрдэс” ХХК-ийн MV-000713 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ын даргын 2005 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн 173 тоот шийдвэрээр 375.18 га “Нарантолгой” нэртэй талбайг шилжүүлэн авсан.

Манай компани нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших 375.18 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-000713 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд Нарантолгойн алтны үндсэн ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2037 он хүртэл хүчинтэй, АТТХуулийн дагуу 10 жилээр 2 удаа сунгагдах эрх нь нээлттэй. БНХАУ-аас 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд 2006 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийгдсэн.

## 1.2. Нарантолгойн алтны ордны геологийн бүтэц

Нарантолгойн орд нь террейний ангиллаар (Г. Бадарч ба бусад, 2002) арлан нумын бассейн болох Хараа террейнд (Хараа голын бүс) байрлах ба Хараа террейнтэй металлогений дүүрэгчлэлээр давхцдаг Хойд Хэнтийн алтны металлогений бүсийн Бороо-Зуун модны хүдрийн дүүрэгт оршино. Хойд Хэнтийн бүс нь өмнөд, зүүн өмнөд талаараа Ерөө голын хагарлын бүс (Сүжигтэйн), баруун хойд, баруун талаар Баян голын гүний хагарлаар тус тус хязгаарлагддаг.

Хараа группын хурдас дотор дээд пермийн гранодиоримийн хил заагийн хэсэг илэрсэн гидротермаль хувирлын бүс бүхий нэлээд их талбайд болон гүн рүү үргэлжилсэн хэсэгт Кварцийн үндсэн ба зэрэгцээ судлууд байрлана. Мөн кварцийн судлын салбарласан хэсэг, олон тооны янз бүрийн чиглэлд (зүүн, хойш, зүүн хойш) сунасан кварцийн хялгасан судлууд тохиолдоно.




Зураг 3. Хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ (блок загварчлалаар, хойшоо харсан байдал)

Нарантолгойн алтны ордын хүдрийн хэмжээ, металлын шинэчилсэн нөөцийн тооцоог “Авсолют Майнинг” ХХК Майкромайн программын блок загварчилалд утга тараах арга ашиглан Бодитой (В) зэргээр ордын хэмжээнд 6.37 г/т алтны дундаж агуулгатай 388,489.00 тн хүдэр бүхий 2744.13 кг алт, Боломжтой (С) зэргээр 7.44 г/т алтны дундаж агуулгатай 695,000.50 тн хүдэр бүхий 5813.13 кг алтыг тус тус тооцоолж, нийт (В+С) 6.88 г/т алтны дундаж агуулга бүхий 1,083,489.51 тн хүдэр буюу 8557.26 кг алтны нөөцийг тооцсон байна. АМГ-ын 2015-03-24 өдрийн Н/26 тоот тушаал болон 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн УУЯ, АМГ-н ХХ-01-12 дугаар бүхий Эрдэс баялагийн зөвлөлийн дүгнэлтээр 736,479.48 хүдэр буюу 8185,35 кг алт, 36178,49 кг мөнгө гэж баталсан байна.

### 1.3. Цаг уур, уур амьсгалын онцлог

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын хоногийн хэлбэлзэл нэлээд өндөр (хавар, намар). Өвлийн улирал нь хахир, хүйтэн, 11-р сараас 3-р сар хүртэл харьцангуй удаан үргэлжилнэ. Хамгийн их хүйтэн нь 1-р сард  $-48^{\circ}\text{C}$ -д хүрнэ. Тогтвортой цасан бүрхүүл 11-р сарын дундаас 3-р сарыг дуустал үргэлжилдэг. Хөрсний хөлдөлт 9-р сарын дундаас 5-р сарын сүүлч хүртэл үргэлжлэх бөгөөд гүн нь өвөлдөө 3.0 м хүрэх боловч мөнх цэвдэг байдаггүй. Хаврын улирал 3-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн хүртэл үргэлжлэх ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, агаарын хуурайшилт их, хүчтэй салхитай байдаг. Зун нь бусад улирлаас арай богино, агаарын хамгийн их халуун 7-р сард нэмэх  $19-26^{\circ}$ -д хүрнэ. Жилд орох хур тунадасны хэмжээ 300-400 мм, түүний 60-80% нь 7, 8-р саруудад унадаг бөгөөд хур тунадастай өдрийн тоо жилд дунджаар 60 хоног. Салхины дундаж хурд 4-8 м/сек, голдуу баруун-хойд, хойд, зүүн-хойд зүгээс салхилах бөгөөд заримдаа 20-22 м/сек хүрдэг (Монгол Улсын Үндэсний атлас, 2009 он).

Жаргалант суманд 1964 оноос цаг уурын харуул ажиллаж байсан ба 1993 онд цаг уурын өртөө байгуулагдсан. Уг цаг уурын өртөө хойд өргөргийн  $48^{\circ}31'$ , зүүн уртрагийн  $105^{\circ}53'$ -г, далайн түвшнээс дээш 990 м өндөрт оршино.



Зураг 4. Цаг уурын ОЖД мэдээ, Жаргалант сумын цаг уурын харуулын мэдээ

Судалгааны талбай нь газар зүйн байрлалаар Хэнтий уулсын баруун хэсгийн захын нам уулсын бүсэд байршина. Орд нь Монгол орны хангай, тал хээрийн завсрын бүсэд хамаарах бөгөөд газрын гадаргуугийн өндөржилт нь Нарантолгой уул 1246.2 м, Жаргалантын гол, Тал булагийн гол, Бяцхан булагийн хөндийнүүдээр эргэн тойроны уул толгодоос тусгаарлагдсан харьцангуй өндөр уулсыг бүрдүүлж байна. Нарантолгой уул нь хойноосоо урагш сунаж тогтдог бөгөөд уулын хойд хэсэг нь бүнхэр хэлбэрийг үүсгэнэ. Энэ уул нь 1-2 м-ийн гүнтэй олон тооны хуурай жалга сайруудаар хэрчигдсэн байна.

Усан сүлжээ нь Хойд мөсөн далайн ай савд багтах ба талбайн баруун хэсгээр Жаргалантын тогтмол урсацтай гол урсаж Загдалын голд цутгадаг. Загдалын гол нь Хараагийн голд цутгана.



#### 1.4. Нарантолгойн уурхайн техник эдийн засгийн үндэслэл

Төсөл хэрэгжүүлэгч “Тэн Хун” ХХК нь Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших Нарантолгойн алтны үндсэн ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, далд уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

Нарантолгойн алтны үндсэн ордыг 1966-1970 онуудад Германы геологичид илрүүлж байсан бөгөөд 2013 онд нарийвчилсан хайгуулын ажлын гүйцэтгэж 2015 онд улсын нэгдсэн нөөцийн санд бүртгүүлсэн байна.

Алтны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар “Тэн Хун” ХХК нь “Восток-Эрдэс” ХХК-ийн MV-000713 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ын даргын 2005 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 173 тоот шийдвэрээр 375.18 га “Нарантолгой” нэртэй талбайг шилжүүлэн авсан.

Нарантолгойн алтны үндсэн ордод хамаарах MV-000713 дугаартай тусгай зөвшөөрлийг БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Тэн Хун” ХХК эзэмшиж байгаа бөгөөд уг ордыг далд уурхайгаас ашиглах ТЭЗҮ-ийг 2009 онд Уул уурхайн хүрээлэн боловсруулж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү ТЭЗҮ-ийг боловсруулах явцад Уул уурхайн хүрээлэнгийн мэргэжилтнүүд мэргэжлийн шинжээчдийн баг бүрдүүлэн ажиллаж зохих дүгнэлтүүдийг хийсэн.

Төв аймгийн Жаргалант суманд орших MV-000713 тоот тусгай зөвшөөрөлд Нарантолгой алтны үндсэн ордод 2013 онд хийгдсэн нөөцийг дахин тооцож шинэчилсэн нөөцийн тооцоог 2014 он “АВСОЛЮТ МАЙНИНГ” ХХК нөөцийг дахин тооцож шинэчилсэн нөөцийг Эрдэс баялгийн зөвлөлд оруулжээ. Ашигт малтмалын газрын 2015-03-24 өдрийн Н/26 тоот тушаал болон 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн УУЯ, АМГ-н ХХ-01-12 дугаар бүхий Эрдэс баялагийн зөвлөлийн дүгнэлтээр нөөцийг баталж хүлээн авсан.


Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Ашигт малтмал, газрын тосны газар эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2021.05.19-ны өдөр “Тэн Хун” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Гоулдмэн Прожект” ХХК боловсруулсан Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хэлэлцэж № Т/21-09-07 дүгнэлтийг гаргасан. Энэхүү дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Т/211 тоот тушаалаар Нарантолгой алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол /1/-ыг хүлээн авсан. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ерөний мэдээлэл, геологи, далд уурхайн технологи, баяжуулах үйлдвэр, дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, хөдөлмөр хамгаалал гэсэн хэсгүүдээс бүрдэх ба төслийн мэдээллийг ерөнхий байдлаар үзүүлсэн байна.

### 1.5. Уурхайн гол барилга байгууламж

Нарантолгойн алтны үндсэн ордыг ашиглах далд уурхайн гадаргуугийн барилга байгууламжуудад уурхайн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах бүх барилга байгууламжуудыг бий болгосон.

Нарантолгойн уурхайд 2006-2017 оны хооронд хөрөнгө оруулалт жил бүр хийгдэж ирсэн бөгөөд нийт 11.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Тус хөрөнгө оруулалтын үлдэгдэл өртөг нь 2020 оны 01-р сарын 01-ний байдлаар 2.86 тэрбум төгрөг байна.

Уурхайд ажиллах ажилчид нь уурхай дээр байрлах бөгөөд 52x8 м талбай бүхий 6-12 өрөөтэй, сэндвич хавтангаар барьсан 12 ширхэг нэг давхар байрнууд (Зураг 3), спорт заал, автограж, уурын зуух, хоолны газар, угаалгын байр, эмнэлгийн байр, хүнсний агуулах, зочид буудал, шатахуун түгээх газар зэрэг цогцолборыг баяжуулах үйлдвэрийн урд талд тусгай талбайд барьж байгуулсан болно. Мөн 3-н давхар тоосгоор барьсан уурхайн оффисын байрыг 2012 онд барьж ашиглалтанд оруулсан байна. Уурхайн оффисын байр ашиглалтанд орсноор ажилчдад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тогтмол явуулах болсон байна.



**Тайлбар:** 1- Усны өрөө, 2- Уурын зуух, 3- Агуулах, граж, 4- Ажилчдын өрөө, 5- Эмэгтэй ажилчдын өрөө, 6- Соёлын танхим, 7- Хоолны газар, 8- Гал тогоо, 9- Хогийн цэг, 10- Гадаа жорлон, 11- Ус буцалгах өрөө, 12- Нүүрсний агууламж, 13- Спортын талбай, 14- Хурлын танхим, 15- Уурхайн хэлтэс, тасаг, 16- Уурхайн захиргаа, эмнэлгийн пункт

**Зураг 5. Нарантолгойн алтын уурхайн захиргаа, ажилчдын байрны цогцолборын бүдүүвч зураг**

### 1.5.1. Далд уурхайн барилга байгууламж

Нарантолгойн алтны үндсэн ордыг ашиглах далд уурхайн үндсэн барилга байгууламжинд хүдрийн биетийг нээхэд зориулагдсан 3 гол ам №1, №2, №3, №4, босоо мухар ам №2 нэмж гүнзгийрэх ба түвшний агааржуулалтын болон тээврийн штрекүүд, кваршлегүүд, уурхайн их амуудын ойролцоох байгууламж зэрэг малталтуудыг шинээр нэвтрэхээр байна.

Далд уурхайн ашиглалтын явцад уулын малталтаар хайгуул хийж, нөөцийг нэмэгдүүлэх, өсгөх боломжийг судлах бөгөөд суналын дагуу хоёр тийшээ болон гүнрүү нөөц өсөх магадлалтай байгаа болно.



Зураг 6. Далд уурхайн босоо ам



### 1.5.2. Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэрийн барилга нь 100 х 40 м талбай бүхий хүдэр бутлах, баяжуулах, хаягдлыг саармагжуулах хэсэг цехүүд зэргээс бүрдэнэ. Нарантолгойн алтны үндсэн ордын хүдрийг БНАГУ-ын Фрайбергийн эрдэм шинжилгээний институт болон ЗХУ-ын “ВНИЙ промзолото” институтэд лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд тулгуурлан БНХАУ-д түгээмэл хэрэглэгдэж байгаа гравитац болон цианаар уусгах (CIP технологи) баяжуулалтын аргыг хэрэглэж боловсруулалт хийхдээ 2 шатны бутлуур сонгож авсан.



Зураг 7. Баяжуулах үйлдвэр


Баяжуулах технологи нь алтыг цианаар уусгаж, электролизийн аргаар тунгаан цэвэршүүлээд, металлургийн аргаар хайлуулан боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Баяжуулах үйлдвэр өдөрт 300 тн, жилд  $9 \times 10^4$  тн хүдэр боловсруулж, баяжуулах металл авалт 90.5%, хайлуулах металл авалт 99% байх бөгөөд жилийн 300 хоногт үйлдвэрлэл явуулж, жилд 260 кг алт, 200 кг мөнгө гаргаж авахаар тооцоолсон.

Баяжуулах үйлдвэр нь дараах үндсэн цех хэсгүүдтэй. Үүнд:

- Бутлах цех
- Баяжуулах цех
- Хаягдлын сан

Бутлах цех нь 27 x 6.6 м талбай эзэлсэн нэг давхар барилга бөгөөд дотроо 350 мм-ийн хөдөлгөөнгүй шигшүүр бүхий 900 x 1240 маркийн бутлуурын тэжээгч, засварын ажилд хэрэглэх өргөх төхөөрөмж, 2 шатны хацарт бутлуур, туузан дамжуулагч, бутлагдсан хүдийн агуулах зэрэг тоног төхөөрөмжийг агуулдаг.

Бутлагдсан хүдийн бункер нь 2м x 1м x 1м хэмжээтэй байна. бутлагдсан хүдэр туузан дамжуулагч тээвэрлэгдэн бункерт хийгдэх ба эндээс тээрийн тэжээгчээр дамжин баяжуулах хэсэгт шилжшинэ.



Баяжуулах хэсэг нь 45 x 29.7м талбай эзэлсэн байгууламж юм. Барилгад 2 шатны тээрэм, ангилах төхөөрөмжүүд, гравитациар баяжуулах төхөөрөмжүүд, гидрометаллургийн боловсруулалтын төхөөрөмжүүд болон ус, булингын шахуурга зэрэг бусад төхөөрөмжүүд байрлана. Барилгын 14 м урттай эхний хэсэгт нунтаглах, ангилах процессын тоног төхөөрөмжүүд, дараагийн 18 м-тэй хэсэгт гравитацийн баяжуулалтын төхөөрөмжүүд болон өтгөрүүлэгч байрлуулсан байна.

Үлдсэн 12.5 м урттай хэсэгт гидрометаллургийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Мөн засвар үйлчилгээний зориулалт бүхий талбайтай. Хаягдал болон алт цэвэршүүлэх хэсэг нь барилгын үлдсэн 13 м урттай хэсэгт зэрэгцээ байрладаг. Мөн үүний хэсэгт хаягдлыг саармагжуулах тоног төхөөрөмж бүхий хэсэг байрлаж байна.

### 1.5.3. Хаягдлын далан

Нарантолгойн ордын нөөц, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаанд үндэслэн хаягдлын санд хуримтлагдах хаягдлын нийт эзэлхүүнийг тогтоож баяжуулах үйлдвэрийн технологи, холбогдох дүрэм, шаардлагуудад тулгуурлан хаягдлын шинж чанарыг тодорхойлж хаягдлын далангийн бүтэц, хаягдлыг байршуулах төлөвлөгөөг гаргаж байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тодорхойлж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.

Нарантолгойн уурхайн баяжуулах үйлдвэрийн баруун аманд байдаг бөгөөд 18 га ашигтай талбайтай 1,0-1,5 сая м<sup>3</sup> хаягдлыг хадгалах боломжтой байсан бөгөөд нэмэлт өргөтгөлийн ажлыг 2019 онд шинээр хийж 180,000 тн нэмэгдүүлсэн (Зураг 7. GoogleMapsPro). Уг талбай нь зүүн урагш харсан хонхор уулын аманд байгаа нь салхиар тоос тараагдах боломж бага. Ашиглалтанд аваад 9 жил өнгөрөхөд ан цав хагарал, гадаргийн эвдрэл, цөмрөлт суулт ажиглагдаагүй. Үер, гадаргын уснаас хамгаалах шуудуу, даланг хамгаалсан. Хаягдлыг ул, хананд нэвчих байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалж 3 мм-н зузаантай зориулалтын нийлэг материалаар (PVC)-р бүрэн доторлосон.




Зураг 8. Хаягдлын далан

Баяжуулахаас гарсан шаварлаг хаягдлыг  $\Phi 5000 \times 5600$  хэмжээтэй тусгай зориулалтын торхонд шингэрүүлж усанд уусган дэвээж хоргүйжүүлэх торхонд хийж уусмал дахь цианийн хэмжээг  $0,1 \text{ мг/л}$  болтол бууруулна. Хаягдал дахь цианийн агуулга  $0,1 \text{ мг/л}$  болгосноор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хүрэх бөгөөд байгаль орчин хүн амьтанд сөрөг нөлөө үзүүлэхгүй аюулгүйн хэмжээнд байна гэж үзэж болно.

Далангийн аюулгүйн хяналт: Хуурай хаягдлын далангын байрлал нь баяжуулах үйлдвэрийн баруун талд оршдог. Далангийн өргөн  $500\text{м}$ , урт  $600\text{м}$ , ус агуулах талбай  $300000\text{м}^2$ , далангийн суурийн өндрийн тэмдэглэгээ  $1093\text{м}$ , тооцоолсон ашиглах өндрийн хэмжээ  $32\text{м}$ , дундаж налуу  $5^\circ$ . Анхдагч даланг хаягдал чулуу болон баяжуулах үйлдвэрийн хөрснөөс гарсан холимог чулуугаар байгуулсан. Үүнд:

- Далангийн суулт, элэгдэл, эвдрэл
- Ус зайлуулах суваг шуудуу
- Усны ба хяналтын цооногын шинжилгээ
- Хаягдлын гадаргуугийн хяналт
- Агаарын тоосны шинжилгээ г.м



Зураг 9. Хаягдлын далангийн схем

- Цэнхэр шугам- ус нэвчих үеийн хязгаар
- Шар шугам- хагарах хүчдэлийн бүс
- Улаан шугам- болзошгүй эвдрэлийн хүрээ



#### 1.5.4. Цахилгаан эрчим хүчний хангамж

Нарантолгойн уурхай нь цахилгаан хангамжийн нэгдсэн системд холбогдсон бөгөөд уурхайн бүх цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид нь нэгдсэн системээс хангагдаж байна. Цахилгааны эх үүсвэр нь 2500кВА-ын хүчин чадалтай 110/10кВА-ын дэд станцаас тэжээгдэж байна. Уурхайн цахилгаан эрчим хүчийг дараах байдлаар хангаж ажиллаж байна. Үүнд:


- |   |    |
|---|----|
| ➤ Худгийг 10/0,4 кВ-ын 100 кВА-ын чадалтай дэд станц  | 1ш |
| ➤ Уурхайн хэрэглэгчдийг 200 кВА-ын чадалтай дэд станц | 2ш |
| ➤ 400 кВА-ын дэд станц                                | 1ш |
| ➤ Баяжуулах үйлдвэрийг 1000 кВА-ын чадалтай дэд станц | 1ш |
| ➤ Ажилчдын байрыг 200 кВА-ын дэд станц                | 1ш |




Зураг 10. Уурхайн дэд станц оролтын шугамын хүчин чадал (35000V)

Гадаад цахилгаан хангамж: Нарантолгойн ордоос урагш 3-5 км зайд Борнуур-Цагаанбулагийн 110/35/10 Кв-н өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Борнуур-Угтаалыг холбосон 35 Кв-ын шугам тус тус дайран өнгөрдөг. Нарантолгойгоос 2 км зайд орших Талбулаг баг нь Жаргалант сумаас эрчим хүчээр хангагдах ба Жаргалант сумаас татсан 10 кВ-н цахилгаан дамжуулах шугам, 10/0.4-н 4 кВА-н дэд станцтай (Зураг 6). Уурхай нь цахилгаан хангамжийн нэгдсэн системд холбогдсон ба уурхайн цахилгаан хангамжид зориулсан нийт 5 дэд станц байдаг. Уурхайн цахилгааныг эрчим хүчээр хангахын тул 10 кВ-н шугамууд, 10/0.4 кВ-ын дэд станцуудыг барьсан (Зураг 9).





Зураг 11. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн ерөнхий байршил



Зураг 12. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн ерөнхий схем

### 1.5.5. Усан хангамж

Технологийн болон ундны усан хангамжинд гүний 1 худгийг ашигладгаас гадна 3-р босоо ам, хаягдлын даланд тогтсон усыг эргүүлэн ашиглах замаар баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээг хангаж байгаа болно. Гүний худгийн усны ундарга 2.6 л/сек. Технологийн усны гол хэрэглэгч нь баяжуулах үйлдвэр юм.

Баяжуулах үйлдвэр нь нийт хэрэгцээт усны 20 хувийг шинэ усаар, 80%-ийг эргэлтийн усаар ашиглаж байгаа болно. Өдөрт хэрэглэх эргэлтийн усны нийт хэмжээ 1267.8 м<sup>3</sup> байх бөгөөд энэ нь нэг тн хүдэр баяжуулалтанд 4.2 м<sup>3</sup>/тн зарцуулалттай байна. Эргэлтийн усанд нэмж оруулах цэвэр усны хэмжээ 20% байх бөгөөд цэвэр усны зарцуулалт 0.71 м<sup>3</sup>/тн байна. Баяжуулах үйлдвэрт өдөрт дунджаар 300 тн хүдэр баяжуулах бөгөөд өдөрт шаардлагатай цэвэр усны хэмжээ 214.2 м<sup>3</sup> байна. Энэ нь цагт 8.9 м<sup>3</sup>/цаг буюу 2.4 л/сек ундарга шаардана.




Зураг 13. Ахуйн болон технологийн хэрэглээний гүний худаг

### 1.5.6. Химийн бодисын агуулах

“Тэн Хун” ХХК-ны үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисуудыг “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 6458:2014 стандартын дагуу ангилах, хадгалах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Тус компанийн баяжуулах үйлдвэрлэлд Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтдаг натрийн цианидыг тусгай зөвшөөрлөөр ашиглагддаг бөгөөд Нарантолгойн уурхайн баяжуулах үйлдвэрийн зүүн урд талд 270 метр зайд стандартын зайн хэмжээн дагуу цианит натрийн төв агуулах байрлаж байна. Агуулахын хашааны дотор хашааг тойрсон шуудуу бүхий усны хамгаалалттай ба цооногоос ус татах насостой. Мөн галын аюулаас хамгаалах хэрэгслийн сараатай. Галын хор болон бусад багаж хэрэгсэл бүрэн байгаа болно. Хашааны гадна 55 метрийн зайд харуулын байртай. Цементэн талбайтай, төмөр торон хашаатай, хамгаалалтын өргөст тортой.

“Тэн Хун” ХХК алтны хүдэр боловсруулах үйлдвэрийн зүүн урд талд 270 метр стандартын зайд цианид натрийн төв агуулах байрладаг. Цианид натрийн агуулах нь 22 тн 11 ширхэг контейнерээс бүрдэнэ. Контейнер тус бүр нь 2 цоож болон лацтай. 24 цагын турш хяналтын 2 камер, хөдөлгөөн мэдрэгч дохиололтой, харуул хамгаалалтын байнгын нэг хамгаалагч хяналт тавин ажилладаг. Өдөрт 2 удаа холбогдох ажилчид шалгалт хийж тэмдэглэл хөтөлдөг байна. 2 тод гэрэлтүүлэгтэй, хашааны дээгүүр өргөст тороор хамгаалагдсан, лацадсан цоожтой байдаг. Агуулахын хашааны дотор хашааг тойрсон шуудуу бүхий усны хамгаалалттай ба цооногоос ус татах насостой. Мөн галын аюулаас хамгаалах хэрэгслийн сараатай. Галын хор болон бусад багаж хэрэгсэл бүрэн байгаа болно. Хашааны гадна 55 м зайд харуулын байртай. Цианид натрийн нөөцийн агуулахын суурь талбай нь 30 м урт, 25 м өргөн, нийт 750 м<sup>2</sup> талбайг 30 см зузаан цементэлж байгуулсан байна.



Зураг 14. Химийн бодисын агуулах

### 1.5.7. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа болон баяжуулах үйлдвэрийн технологийн шат дамжлага бүрд хяналт тавих зорилгоор баяжуулах үйлдвэрийн дэргэд шинжилгээний лаборатори ажиллаж байна.

Лаборатори дараах үндсэн үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Хүдрийн найрлагыг судлах
- Хүдэр дэх металлын агуулгыг тодорхойлох
- Технологийн шат дамжлага бүрийн бүтээгдэхүүнүүдэд шинжилгээ хийж чанарын хяналт тавих
- Технологид хэрэглэж байгаа усны болон уусмалын агуулгыг хянах
- Хаягдал дахь хорт бодисын хэмжээнд хяналт тавих

Дээрх үйл ажиллагааг явуулахын тулд баяжуулах үйлдвэрийн шинжилгээний лаборатори нь дараах нэгж хэсгүүдээс бүрдэнэ.

- Дээж авч шинжилгээнд бэлтгэх хэсэг
- Металл хайлуулах цех
- Хими, спекторийн шинжилгээний хэсэг

Лабораторийн үйл ажиллагаа үйлдвэрийн үйл ажиллагаантай зэрэгцээ явагддаг.



Зураг 15. Баяжуулах үйлдвэрийн лаборатори



### 1.5.8. Техникийн засвар үйлчилгээний барилга байгууламж

Уурхайн засварын үйлчилгээний дэд бүтэц нь уулын механик тоног төхөөрөмж, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттай.

Ашиглалтын үйлчилгээний өндөр түвшин, материал техникийн хангамжийн найдвартай системээр уурхайд ажиллаж буй бүх тоног төхөөрөмжийн хэвийн ашиглалтыг хангахад үндэслэн засвар техникийн үйлчилгээний ажлын хэмжээг тооцно. Уурхайн засвар техникийн үйлчилгээний дэд бүтцийн зориулалт, зохион байгуулалтын схем боловсруулалт, гарсан тооцооны дагуу дор дурьдсан бүтцийг төсөлд сонгож авсан болно. Үүнд:

1. Уулын механик тоног төхөөрөмжийн агрегатын засварын хэсэг, зөөврийн засвар техникийн үйлчилгээний бригадын хамт
2. Автомашины агрегатын засвар техникийн үйлчилгээний хэсэг
3. Механик цех
4. Цахилгаан тоноглолын засварын хэсэг
5. Материал сэлбэгийн агуулах
6. Автомашины гараж



Зураг 16. Техникийн засвар, үйлчилгээний барилга

### 1.5.9. Тэсрэх материалын агуулах

Тэсрэх материалын агуулах нь тэсрэх бодисын, тэсрэх хэрэгслийн, түгээх байр, харуулын байр гэсэн нийт 4 барилгатай.

Тэсрэх материалын агуулах нь уурхайн тэсэлгээний ажилд шаардагдах тэсрэх материалыг хадгалах, түгээх үндсэн үйл ажиллагаатай. Нарантолгойн уурхайд ашиглах тэсрэх бодисыг “Мон Маг” ХХК 2023 онд ханган нийлүүлсэн. Уурхайн тэсрэх материалын агуулахын онцгой хамгаалалтын барилга байгууламжийг 2009 онд барьж ашиглалтанд оруулсан. Тус агуулахад харуул хамгаалалтын 2 ажилтан, агуулахын нярав 2 ажилтан ажиллаж хамгаалдаг. Тэсрэх материалын агуулах нь Нарантолгойн уурхайн лицензийн талбай дотор шороон далангаар хамгаалсан хагас далд хэлбэртэй блокоор барьж шавардсан. Агуулахын талбайг бүрэн гэрэлтүүлэхээр тал бүрээс нь 5 ширхэг гэрэлтүүлгээр гэрэлтүүлсэн. Галын цэг болон гал унтраах хэрэгслээр тоноглогдсон. Тэсрэх материалын агуулахын багтаамж нь 20 тн юм.

Тэсрэх материалын агуулахын нутаг дэвсгэрийн зориулалтын талбайд цэнэглэгч машинд болон тэсрэх бодис бэлтгэж үйлдвэрлэх суурин цэгт тэсрэх бодис 2 хоногоос илүүгүй хугацаагаар хадгалахыг зөвшөөрнө. Уурхайн их ам болон налуу малталтын гүнзгийрэлтийн үед тухайн ээлжинд хэрэглэх тэсрэх материалыг эдгээр малталтын амнаас 50 м-ээс багагүй зайд тусгайлан бэлтгэсэн байранд хадгална.



Зураг 17. Тэсрэх материалын агуулах



**1.5.10. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц (ШТС)**

Шатахуун цэнэглэх станцын ажлын зургийг Монгол улсын стандарт MNS 4628 98-ийн зааврыг баримтлан 2009 оны 4-р сард “АКСИОМ констракшн” ХХК-нд доорх байгаль цаг уурын нөхцөлд тохируулан боловсруулан гүйцэтгэсэн. Үүнд:

Гадны агаарын температур 34.3 градус

Салхины хүч 35 кг/м.кв

Цасны ачаалал 50 кг/м.кв

Шатахуун цэнэглэх станцын В20 маркийн бетон хучилттай тавцанг зүүн тийш конторын барилгатай зэрэгцээ /створ/, авто замаас 15 м-ийн зайд байрлуулсан. Орох замын эхэн дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарласан замын тэмдэг болон галын аюултай бүсийг анхааруулсан тэмдгийг байрлуулсан.



Зураг 18. Шатахуун түгээх станц

1.6. “Тэн Хун” ХХК-ний байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд

1.6.1. “Тэн Хун” ХХК-ны эзэмшдэг тусгай зөвшөөрөл

Хүснэгт 3. “Тэн Хун” ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Дугаар	Хүчинтэй хугацаа
А. Ашигт малтмал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөл			
1	Нарантолгой ордоос ашигт малтмал ашиглахыг тусгай зөвшөөрөл	MV-000713	2007.01.23-30 жил

1.6.2. Газар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ

Хүснэгт 4. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ м/кв	Хүчинтэй хугацаа
1	Уул уурхайн үйлдвэрийн барилга, байгууламж	0000104232	19984	2022.07.04-2027.07.07
2	Нөөц газар	600104227	3737683	2022.07.04-2027.07.04

1.6.3. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл

Хүснэгт 5. Байгаль орчны холбогдох зөвшөөрөл, хүчинтэй хугацаа

№	Газар эзэмших зориулалт	Дугаар	Хүчинтэй хугацаа
1.	Химийн бодис ашиглах зөвшөөрөл	0002622	2024.01.22-2029.01.22
2.	Химийн бодис ашиглах зөвшөөрөл	0001836	2021.03.29-2024.12.31
3.	Ус ашиглуулах дүгнэлт	E-2405-000002	2024.12.31
4.	Ус ашиглах зөвшөөрөл	A/08	2024.12.31
5.	Галын аюулгүй байдлын дүгнэлт уул уурхай олборлолт	0019332	2024.10.08-2026.10.08



#### 1.6.4. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлан

“Тэн Хун” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах Нарантолгойн уурхайн газарт орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр жил бүр хэрэгжүүлж байна.

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Их Зос” ХХК төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын үе шатанд нөлөөлөлд өртөж буй байгаль орчны бүрдэл хэсгүүд буюу агаарын чанар, дуу шуугиан, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, гадаргын усанд хяналт-шинжилгээ хийх хийх цэгүүдийн байршил, дээж авах зэрэг ажиллуудыг гүйцэтгэсэн.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянахад Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр чухал ач холбогдолтой юм.

Нарантолгой уурхай 2016 оноос 2024 хүртэл “Их Зос” ХХК-иар төслийн талбайн орчны хяналт шинжилгээний мониторингийг жилд 2 удаа гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр уурхайн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг жилүүдийн хооронд тодруулах, тухайн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулж, уг зөвлөмжийн дагуу арга хэмжээ авахад оршино.

#### 1.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нийт зардал

Нарантолгойн уурхайн MV-000713 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдана. Уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндсэн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно. 2024 оны байгаль орчны төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт жаран есөн сая жаран таван мянган (72,040,000) төгрөг төлөвлөсөн байна.

## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Уурхайн ашиглалтын нийт хугацаанд байгаль орчинд, экологийн үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомж, дагаж мөрдөх стандартуудыг үндэс болгон ажиллана. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Нарантолгойн алтны орд газрын үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны аудитын тайлан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино.

### 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаагаар малталт нэвтрэлтийн ажил хийгдэх бөгөөд үүний улмаас уурхайн талбайн болон түүнийг хүрээлэх байгаль орчинд зайлшгүй өөрчлөлт гарна. Үүсэж бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээний үр дүн нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийн цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн уулын үйлдвэр, түүний эргэн тойрон дахь бүс нутагт уулын ажлын явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой. Уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд дараах сөрөг нөлөөлөл бий болно гэж үзэж байгаа.

- Олборлолтын үйл ажиллагааны улмаас уурхайн орчны тоосжилт нэмэгдэх магадлалтай.
- Янз бүрийн зориулалт бүхий уулын ажил, хаягдал чулуулгийн овоолго, инженерийн болон аж үйлдвэрийн барилга байгууламж барьж байгуулахад газрын гадарга эвдэрч хиймэл рельеф үүсэх. Газар тариалан, бэлчээрийн зориулалттай талбайн хэмжээ багасаж үр өгөөж нь буурах.

#### 3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагааны улмаас агаарын бохирдолтод нөлөөлөх нөхцөл нь уулын малталтаас үүсэх овоолго, хүдэр тээвэрлэх, хүдэр бутлах, хаягдлын сан, далан барилга байгууламж барих үед үүсэх тоос шороо, хүйтний улиралд уурын зууханд хэрэглэх нүүрсний утаа зэрэг нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.


Агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уухайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, машин техникийн хөдөлгүүрээс гарах хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг бусад хорт хий болно. Агаарын орчинд их хэмжээний тоосжилт үүссэнээр нарийн тоос ургамлын тоос хүртэлтэд сөргөөр нөлөөлж байгалийн аясаар үрээр нөхөн сэргэх үйл явцыг сааруулна. Мөн уурхайн орчинд ажиллаж байгаа ажилчид, нутгийн оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж ая тух алдагдуулах сөрөг үр дагавартай.

Төсөл хэрэгжих бүсэд агаар бохирдуулах гол эх үүсвэрүүдэд нь дараах хүчин зүйлс орно. Үүнд:

- Уурхай дахь машин механизмын үүсгэж буй хөрс ачих буулгах үеийн тоос дэгдэлт
- Дотоод шаталтат хөдөлгүүрийн утаа, тоос

Дээрх хорт бодис, утаа, тоосыг агаарт дэгдэх явцыг бууруулах зорилгоор бага утаа ялгаруулдаг техник, технологи ашиглах, ялгарсан бодисыг агаар мандалаас шүүх арга хэмжээ авах шаардлага гарна. Мөн хаягдлын сангаас цаг агаарын хуурайшилт болон салхи ихтэй үед цагаан тоос дэгдэх, цианидын ууршилтаас агаар орчин бохирдох магадлалтай юм.

Эдгээр нөлөөллийн агаар орчинд учруулах хор хохирол нь бага боловч зохих заавар журмын дагуу ажлыг хийж гүйцэтгээгүйн улмаас агаарын бохирдол үлэмж үүсэх боломжтой байна. Тиймээс уурхайн бүс дэх авто замаас үүсэх тоос, хүдрийн овоолго болон тээвэрлэх, бутлах үйл ажиллагаанаас үүсэх тоосыг бууруулах арга хэмжээнд хяналт тавин ажиллалаа.



Зураг 19. Агаарын чанарын хэмжилт

“Тэн Хун” ХХК-ын Нарантолгой орд орчмын PM1.0, PM2.5, PM10 тоосонцорын хэмжээ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлтгүй байв.

Агаарын бохирдол гэж хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсч бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг хэлнэ.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах зөвлөмжүүдийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Агаар орчинд үүсэх тоосжилтыг бууруулахын тулд Монгол улсад мөрдөж байгаа Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 -д заасан стандарт хэмжээнд барих, хяналт тавин ажиллалаа.
- Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, уурхай болон үйлдвэрт ажиллах бүх ажилчдыг хувийн хамгаалалтын хэрэгсэл, тусгай зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцасаар ханган ажиллалаа. (тоос тоосонцор үүсгэдэг, тухайн орчинд ажил гүйцэтгэх үед нь амьсгалын замын эрхтнийг хамгаалах зориулалтын шүүлтүүртэй маск, комбинзон зэрэг хамгаалах хувцас хэрэгсэл)

### 3.2. Хөрс орчинд үзүүлэх нөлөөлөл

Нарантолгойн алтны үндсэн ордын район нь хөрс газарзүйн мужлалтаар хар хүрэн, цайвар хүрэн хөрстэй Орхон-Сэлэнгийн тойргийн хээрийн бүсэд багтана. Орд газрын ашиглалтын талбайн хөрс зүүн талаараа өндөрлөг уулын налуугийн шимт хөрстэй бөгөөд зарим хэсэгтээ асгат угаагдмал болон үржил шим муутай чулуулаг хөрстэй. Харин уулын хормой, баруун, баруун хойд, хойд хэсгээрээ үржил шимээр арвин, чанарын үзүүлэлтээр өндөр үнэлгээтэй манай орны хэмжээнд хамгийн сайн хөрстэй газарт тооцогдоно.

Төсөл хэрэгжих орчны хөрсний үндсэн шинж, нягт, нөөц, найрлагад үнэлгээ өгч хөрсний шинж чанарт гарах өөрчлөл, сөрөг үр дагавар, хамгаалах арга хэмжээг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэл боловсруулж байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгана. Уурхайн ажлын явцад барилга байгууламжийн талбайн шимт хөрс хуулалтын ажлыг технологийн дагуу явуулна. Өнгөн хөрсийг уурхайн хаалтын үед биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах ба хадгалах хугацаанд элэгдлээс хамгаалж доторх бичил организмын амьдралыг тэтгэх үүднээс гадаргууг нь ургамалжуулах ажил хийнэ. Нутгийн хөрсний эмзэг байдлыг харгалзан үзэж хөрсний эвдрэлийг бууруулах зорилгоор ногоон байгууламжийг уурхайн эргэн тойронд байгуулсан.

2016-2024 онуудад мониторингийн цэгүүдээс хөрсний 6 ш зүсэлт хийж, хөрсний морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, хөрсний үе давхарга бүрээс лабораторийн задлан шинжилгээнд зориулан хаягдлын далан, саармагжуулах цех, хаягдал тээврийн замын өнгөн хөрснөөс 3 ш дээж нийт хөрсний 9 ш дээж авсан.



### 3.2.1. Хөрсний хүнд металлын шинжилгээ

№	Дээжийн дугаар	Хүнд металлын агууламж										
		Элемент %					Элемент мг/кг					
		Al*	Ca	Mg	K	Fe <sub>нийт</sub>	As	Ba*	Be	Bi	Cd	
1	NA-01 А-үе											
2	NA-02 А-үе	1.94	0.55	0.58	0.33	2.7	6	120	0.7	<2	<0.5	
3	NA-03 А-үе	1.48	11	0.82	0.14	1.96	8	80	0.5	<2	<0.5	
4	NA-04 А-үе	1.48	5.73	0.65	0.14	2.11	9	80	0.6	<2	<0.5	
5	NA-05 А-үе	2.22	0.63	0.77	0.4	3.01	9	150	0.8	<2	<0.5	
6	NA-06 А-үе	2.12	0.55	0.79	0.25	2.96	6	90	0.8	<2	<0.5	
Хүлцэх агууламж MNS5850:2019							20.00				3.00	
Хортой агууламж MNS5850:2019							50				10	
Аюултай агууламж MNS5850:2019							100				20	
		Элемент мг/кг										
		Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb	
1	NA-01 А-үе											
2	NA-02 А-үе	11	36	20	20	20	542	1	23	680	10	
3	NA-03 А-үе	9	24	24	20	20	289	<1	23	620	9	
4	NA-04 А-үе	8	25	19	20	20	317	<1	20	660	9	
5	NA-05 А-үе	13	39	27	20	20	663	1	27	660	15	
6	NA-06 А-үе	12	38	20	20	20	452	<1	30	620	12	
Хүлцэх агууламж MNS5850:2019		50.00	150.0	100.0				5.0	150.0		100.0	
Хортой агууламж MNS5850:2019		500	400	500				20	1000		500	
Аюултай агууламж MNS5850:2019		1000	1500	1000				50	1800		1200	
		Элемент %					Элемент мг/кг					
		Al	Ti	Na	S	B	Tl	Ga	Sb	Sc	Sr	Hg
1	NA-01 А-үе								<2			
2	NA-02 А-үе	1.94	0.09	0.2	0.03	10	<10	10	<2	4	52	1
3	NA-03 А-үе	1.48	0.07	0.3	0.05	10	<10	<10	<2	3	298	<1
4	NA-04 А-үе	1.48	0.08	0.2	0.04	10	<10	<10	<2	3	126	<1
5	NA-05 А-үе	2.22	0.1	0.2	0.05	10	<10	10	<2	5	53	<1
6	NA-06 А-үе	2.12	0.11	0.2	0.03	<10	<10	10	<2	5	49	<1
Хүлцэх агууламж MNS5850:2019										10.00	800.0	2
Хортой агууламж MNS5850:2019										50	3000	
Аюултай агууламж MNS5850:2019										100	6000	

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН-2024

Хөрснөөс дээж авч хүнд металлын агууламжийг “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан ба MNS5850:2019 стандарттай харьцуулахад стандартын хүлцэх, хортой, аюултай агууламжаас бага хүнд металлын бохирдолгүй байна.

### Хүснэгт 6. Хаягдлын далангийн шаврын химийн шинжилгээ

№	Элемент, мг/кг	Шинжилгээний дүн	
		2023	2024
1	Cr*	49.58	120
2	Co	<b>11.65</b>	<b>23.34</b>
3	Ni	33.02	35.90
4	Rb	36.62	56.82
5	Mo	<b>5.34</b>	<b>5.33</b>
6	Cd	<b>4.25</b>	<b>6.89</b>
7	Sn*	0.94	1.08
8	Sb	<b>4.05</b>	<b>4.33</b>
9	W*	3.56	7.55
10	Pb	<b>458</b>	<b>365</b>
11	Bi	<b>4.21</b>	<b>1.76</b>
12	Ba	268	267
13	Sr	201	271
14	As	<b>120</b>	<b>39.08</b>
15	Cu	<b>395</b>	<b>169</b>
16	Mn	417	447
17	Ti	745	1769
18	V	49.02	80.89
19	Zn	<b>230</b>	<b>209</b>
20	Fe, %	2.91	3.03
21	CN	7.38	5.72

Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь хортой агуулгаас давсан тохиолдолд тухайн хөрс нь орчин тойронд байгаа амьд организм, усан давхаргад хортой нөлөөлөл учруулна. Хортой агуулгыг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах ЗДХ-тэй адил утгаар мөрдлөг болгодог.

### Хүснэгт 7. Хөрсний зүсэлтийн цэгүүдийн бичиглэлийн мэдээлэл

№	Элемент	Нэгж	Шинжилгээний дүн	MNS5850:2019	Стандарт арга
1	Цианид, CN <sub>tot</sub>	Мг/кг	8.32	25	MNS ISO 6703(I):2005
Хортой агууламж MNS5850:2019				50	
Аюултай агууламж MNS5850:2019				100	

Хаягдлын далангийн баруун урьд хэсэг, тээврийн зам, герман амны доод хэсгүүдэд авсан дээжшинд Цианидын агууламжийг “Геологийн судалгаа шинжилгээний төв”-ийн

лабораторт тодорхойлуулсан ба MNS5850:2019 стандартын хүлцэх, хортой, аюултай агууламжаас бага, цианидын бохирдолгүй байна.

### 3.3. Ургамал, амьтанд үзүүлэх нөлөөлөл

Үйлдвэрлэл явуулах талбайн ургамлын нэр, тархалтыг тогтоож ховор болон нэн ховор ургамлыг хамгаалах, шилжүүлэх арга хэмжээ авна. Тухайн орчинд амьдарч байгаа ан амьтны байршил, тоо толгойг тогтоон уурхайн үйл ажиллагаанаас учрах сөрөг нөлөөллийг тогтоож багасгах, арилгах арга хэмжээ авахаас гадна төслийн явцад ургамал ан амьтанд нөлөөлөх нөлөөллийн хяналтыг явуулна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг зөвхөн олборлолт явуулж байгаа талбайгаас гадна төсөл хамаарагдах дэд бүтэц, усан хангамж, цахилгаан, дулааны эх үүсвэр болон ажиллагсадын оршин суух тосгоны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлант хугацааны эцэст дүгнэсэн. Байгаль орчны хяналтыг жилд 2-оос доошгүй удаа хөндлөнгийн хяналтын байгууллагуудтай хамтран явуулахаас гадна байгаль орчны хяналтыг лабораторийг жилийн турш ажиллуулсан.

2024 оны ургамалжлын судалгааг 06-р сарын 13 өдөр 6 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлын бичиглэлийн цэгүүдэд бүлгэмдлийн бүтэц болон ургамалжлын ерөнхий үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдтэй харьцуулан үзүүлсэн тул 2023 онд ургамал бүлгэмдлийн зонхилогчийн индекс, зүйлийн олон янз байдал болон жигд байдлын индексүүдийг нарийвчлан үзүүлсэн. Олон янз байдлын индекс нь бүлгэмдлийн зүйлийн олон янз байдлын онцлогийг гаргахад өргөн хэрэглэдэг. 1 м<sup>2</sup> дахь зүйлүүдийн бүрхэц болон харьцангуй жигд байдалд үндэслэн, олон янз байдлын индексийг тодорхойлсон.

Зураг 20. Ургамлын зүйлүүдийн биомасс авч буй байдал



### 3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн хүрээнд Нарантолгойн урд 2.3 км байрлах цэгээс 4 метрийн гүнд байрласан 100 мм шугамаар үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний усаа хангахаар төлөвлөсөн. Усны зохистой хэрэглээ, дахин ашиглалтыг үйлдвэрлэл болон ахуйн орчинд хэвшүүлж, усны тоолууржсан системийг ашиглаж, усны бүртгэлийг хөтлөн ажиллаж байна. ТЭЗҮ-нд тусгасны дагуу нийт эргэлтийн усны 80%-ийг дахин ашиглаж, хоногт 300 тн хүдэр боловсруулахад хаягдал шламын чийг, алдагдал 20% буюу хоногт 264 тн усыг нөхөн сэлбэлтээр гүний худгаас авч ашиглана. Мөн далд уурхайн 2, 3, 4 амнаас жилд ойролцоогоор 60 орчим мянгат тн ус шавхагдаж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй гүний худгаас 75 орчим мянган тн ус авч ашиглаж байгаа бөгөөд тухайн ус авч ашиглаж байгаа газруудад гүний усны түвшний бууралт үүснэ. Гүний усны түвшний бууралт, нөхөн сэлбэлтийн талаар гидрогеологийн тооцоо, судалгаа хийгээгүй байна.

Уурхайн ашиглалтаас усан орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ нь юуны өмнө технологийн зориулалтаар ашиглах усны зарцуулалтыг хамгийн оновчтой байлгах, алдагдлыг багасгах явдал юм. Ахуйн хэрэглээний усыг ариг гамтай хэрэглэх, хэрэглэсэн усыг тооцох үүднээс тоолуур тавих, ажилчдын тосгон, хоолны газар, халуун ус, конторын барилга болон бусад барилга объектуудад хэрэглэсэн бохир усыг тухай бүр нь тусгайлан бэлдсэн бохир ус зайлуулах цэгт хаяж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хугацаанд хийж байна.

2024 онд үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэгцээнд ашиглах усыг төлөвлөсөн хэмжээгээр ашиглах бөгөөд ТЭЗҮ, УАТ, БОНБНҮ-д тусгасан жилд хэрэглэх усыг тоон хэмжээнээс хэтрүүлэхгүй, төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулж, усыг хэмнэлттэй ашиглах ажлуудыг зохион байгуулж, ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлж ажилласан болно.

#### 3.4.1. Далд уурхайн шүүрлийн усны судалгаа

2024 оны 3-р сард Босоо ам-1 болон Босоо ам 3-т шүүрлийн усны хэмжилт, гүний худгуудын богино хугацааны сорилын туршилтын ажлыг явуулав. Босоо ам-1 хувьд 1, 2, 3-р түвшний хэвтээ малталтуудаас хүдэр олборлолт хийгддэггүй бөгөөд шүүрлийн усны урсац байхгүй хуурайшсан байна. Харин 5-р түвшний хэвтээ малталтаас ус шүүрч буй нь тогтоогдсон. Босоо ам 1-ийн адил 1-3-р түвшиний хэвтээ малталтуудад шүүрлийн ус ажиглагдаагүй.

Эдгээр газрын доорх шүүрлийн усыг хэвтээ малталтуудаас сувгаар урсгаж босоо гол амны ёроолын мөргөцөгт байх ус хуримтлуулах зумфэд нийлүүлдэг. Босоо ам-3т 5-р түвшинд ус хуримтлуулах 1 зумф, 6-р түвшинд 1 зумф үүсгэсэн.


Зумф болгон руу сувгаар урсан орж ирж буй усны урсгалын өнгөрөлтийг дижитал багаж ашиглан нийлбэр урсацийн хэмжээг тодорхойлсон.



**3.4.2. Усны төлбөр, ус ашиглалтын байдал**

Үйлдвэрлэлд шавхан зайлуулах шүүрлийн ус хэрэглэх ба дутагдах усыг худгаас хангана. Худгийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэж хариу болон дүгнэлтийг сав газрын захиргаанд хүргүүлсэн.

“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 тоот тогтоол, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-г өөрчлөлт оруулах тухай 2013 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ус ашиглалтын төлбөрийг тооцон барагдуулж байна.



Диаграмм 1. 2020-2024 оны усны төлбөр төлөлтийн байдал

### 3.4.3. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ болон дүгнэлт

“Тэн Хун” ХХК-ийн ус ашиглах гэрээнд заасны дагуу жил бүр ус ашиглах дүгнэлтийг “Усны газар”-аар тухайн жилийн ус ашиглах төлөвлөгөөнд үндэслэн зориулалт тус бүрээр гаргуулж байна. Монгол Улсын “Усны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын 2024 оны 08 дүгээр сарын 14-ний өдрийн Е-2405-000002 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2024 оны 08-р сарын 20-ний өдрийн №17 тоот ус ашиглах гэрээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байгуулсан.

Хараа-Ерөө голын сав газарт Нарантолгойн алтны үндсэн ордыг далд аргаар олборлон баяжуулж алт мөнгө олборлох “Тэн Хун” ХХК-д 2024 онд ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд 9,270.0 м<sup>3</sup>/жил, 120,324.6 м<sup>3</sup>/жил усыг шавхан зайлуулж шүүрлийн уснаас технологийн хэрэгцээнд ашиглахыг 2024.08.20-ны А/41 тушаалаар зөвшөөрсөн байна.

#### Хүснэгт 8. Усны гэрээ, дүгнэлтийн мэдээлэл

Гэрээний дугаар	Хугацаа	Эхлэх	Дуусах	Ус ашиглэх зориулалт
17	5 сар	2024.08.20	2024.12.31	<ul style="list-style-type: none"> <li>• Унд ахуйд</li> <li>• Баяжуулах үйлдвэр</li> <li>• Зам талбайн тоосжилт дарах</li> <li>• Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийн хүрээнд урьд жил тарьсан модны усалгаанд</li> <li>• Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийн хүрээнд тарьсан модны усалгаанд</li> </ul>

Ус ашиглах гэрээнд заасанчлан жил бүр ус ашиглах дүгнэлтийг тухайн жилийн ус ашиглах төлөвлөгөөн дээр үндэслэн зориулалт тус бүрээр тооцоолон гаргуулж ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар” байгуулагдсантай холбоотой 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг 2024 оны 08 дугаар сарын 14-ны өдөр “Усны газар”-аар гаргуулсан.

**3.4.4. Усны тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах, тоолуур баталгаажуулах**

Нарантолгойн алтын далд уурхайн 2024 оны тоолуурын эхний заалтыг 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс сүүлчийн заалтыг 2024 оны 09 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд нийт ашигласан усны хэмжээг баталгаажуулсан усны тоолуураар тооцоосон.

**Хүснэгт 9. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-1**

№	Суурилуулсан тоолуурууд	2023.11.29-ны заалт /м³/	2023.12.22-ны заалт /м³/	Тоолуурын гүйлтийн зөрүү /м³/
1.	Унд ахуй №2101400033	7605	7841	236
2.	Унд ахуй №1905000770	30941	31343	402
3.	Баяжуулах үйлдвэр №1405000074	117052	119574	2522
4.	Бутлуурын шүүрлийн усны №202200673	24695	27169	2474

**Хүснэгт 10. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-2**

№	Суурилуулсан тоолуурууд	2023.12.22-ны заалт /м³/	2024.04.30-ны заалт /м³/	Тоолуурын гүйлтийн зөрүү /м³/
1.	Унд ахуй №2101400033	7841	8434	596
2.	Унд ахуй №1905000770	31343	34060	2717
3.	Баяжуулах үйлдвэр №1405000074	119574	127654	8080
4.	Бутлуурын шүүрлийн усны №202200673	27169	39808	12639

Хүснэгт 11. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-3

№	Суурилуулсан тоолуурууд	2023.04.30-ны заалт /м³/	2024.07.01-ны заалт /м³/	Тоолуурын гүйлтийн зөрүү /м³/
1.	Унд ахуй №2101400033	8434	8847	413
2.	Унд ахуй №1905000770	34060	35603	1543
3.	Баяжуулах үйлдвэр №1405000074	127654	127674	20
4.	Бутлуурын шүүрлийн усны №202200673	39808	46461	6653

Хүснэгт 12. Усны баталгаажуулалтын тоолуурын заалт-4

№	Суурилуулсан тоолуурууд	2024.07.01-ны заалт /м³/	2024.09.20-ны заалт /м³/	Тоолуурын гүйлтийн зөрүү /м³/
1.	Унд ахуй №2101400033	8847	9237	390
2.	Унд ахуй №1905000770	35603	37540	1937
3.	Баяжуулах үйлдвэр №1405000074	127674	127687	13
4.	Бутлуурын шүүрлийн усны №202200673	46461	48587	2126

Усны ашиглалтад хяналт тавих үүднээс далд уурхайн шүүрлийн ус татах шугам, үйлдвэрийн болоод унд ахуйн хэрэглээнд дараахь Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулсан тоолууруудыг суурилуулсан.





УНД АХУЙН №2101400033ТООЛУУРЫН ЗААЛТ



УНД АХУЙН №1905000770 ТООЛУУРЫН ЗААЛТ



ҮЙЛДВЭРИЙН ЭРГЭЛТИЙН УСНЫ №1405000074 ТООЛУУРЫН  
ЗААЛТ



ДАЛД УУРХАЙН ШҮҮРЛИЙН УСНЫ №202200673 ТООЛУУРЫН  
ЗААЛТ

Зураг 21. Тоолуурын сүүлийн баталгаажуулалт-2024



### 3.4.5. Сум, орон нутгийн булаг шандны эхийг сэргээн засварлах

Усны тухай хуулийн Баг, хорооны Засаг дарга усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хүрээнд 15.1.2. гол, горхи, булаг, шанд, рашааны эхийг хамгаалах, тохижуулах, мод тарих, ургамалжуулах, ундаргыг нэмэгдүүлэх, бохирдлоос сэргийлэх арга хэмжээнд иргэдийг татан, малчин өрхийн анхдагч холбоотой хамтран жил бүр хамран ажилладаг.

Уг ажлын хүрээнд “Тэн Хун” ХХК-ийн БОХАБЭАХ-ээс 2023, 2024 онд 2 булаг шанд тохижуулах байснаас Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах Хоолтын Амны нойр булчирхай, ходоодны рашаан булгуудыг сонгон авч сэргээн завсарлаж хаягжуулсан (Зураг 19-22). Эдгээр булгууд нь нутгийн иргэдийн аялж, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх гол газруудын нэг юм. 2023.09.24-нд 2 булаг шанд тохижуулах ажлын хүрээнд Нарантолгойн уурхайн БОХАБЭАХ, ТТҮЗҮХ-ийн мэргэжилтнүүд болон сумын байгаль хамгаалагч нутгийн иргэдийн хамтран энэхүү ажлыг зохион байгуулсан.



Зураг 22. “Хоолтын Амны” нойр булчирхайн рашааныг тохижуулахын өмнөх байдал





Зураг 23. “Хоолтын Амны” нойр булчирхайн рашааныг тохижуулсаны дараах байдал



Зураг 24. “Хоолтын Амны” ходоодны рашааныг тохижуулахын өмнөх байдал





Зураг 25. “Хоолтын Амны” ходоодны рашааныг тохижуулсаны дараах байдал

Хүснэгт 13. 2023, 2024 оны рашаан, булаг тохижуулахад орсон нийт зардал

№	Бараа материалын нэр	Нэгж/тоо, ш	Нэг бүрийн үнэ
1.	Цэнхэр будаг	2 кг	20,000
2.	Шар будаг	2 кг	20,000
3.	Багс	4 ш	6,000
4.	Будаг шингэлэгч	1 ш	5,500
5.	Хашаа хийх тор	10 боодол	2,000,000
6.	Төмөр шон	9 ш	90,000
7.	Банз	1 банз	10,000
8.	Хадаас	100 гр	6,000
9.	Төмөр утас	1 боодол	10,000
10.	Бинзен	180 л	430,000
12.	Түлш	80 л	312,000
11.	Хулдаасан хэвлэл	МКВ	120,000
<b>Нийт</b>			<b>3,229,000</b>



#### 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нарантолгой далд ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн ба нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг Байгаль орчин, Аялал жуучлалын яамны сайд, Эрдэс баялаг, Эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар болон МУ-ын хууль болон холбогдох тушаал шийдвэрийг мөрдөн ажиллахаар төлөвлөн хийж гүйцэтгэсэн.

Шимт хөрсний нягт, чийгшил, ерөнхий химийн шинжилгээг хийлгэж хяналт тавих арга хэмжээний хүрээнд шимт хөрсний овоолгын чийгшил, хувийн жин, хүнд металлын химийн шинжилгээг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-аар шинжлүүлсэн болно.

Хүснэгт 14. Шимт хөрсний овоолгын химийн шинжилгээний дүн

№	Элемент, мг/кг	Шинжилгээний дүн		Агтестатчилсан утга
		2023 он	2024 он	
1	Cr*	40.25	59.67	376
2	Co	8.42	9.70	12.66
3	Ni	19.15	26.81	43.84
4	Rb	62.11	63.99	79.04
5	Mo	1.19	1.41	1.30
6	Cd	<b>0.25</b>	0.18	0.22
7	Sn*	1.66	1.64	2.86
8	Sb	1.13	1.13	2.09
9	W*	1.97	3.74	4.74
10	Pb	<b>18.51</b>	<b>20.57</b>	17.42
11	Bi	<0.5	<0.5	0.27
12	Ba	570	589	658
13	Sr	321	348	349
14	As	<5	<b>12.84</b>	7.79
15	Cu	<b>28.26</b>	<b>30.01</b>	23.09
16	Mn	560	<b>644</b>	620
17	Ti	2639	3186	5275
18	V	59.14	81.30	84.50
19	Zn	69.47	62.71	71.40
20	Fe, %	2.89	3.58	3.62
21	CN	<1	<1	12.00

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН-2024

Хөрсний бохирдлын хэмжээг тодорхойлоход “Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2008” стандарттай жишиж дүгнэлт гаргасан. Хөрс бохирдуулагч бодисуудын агуулга нь хөрсөнд байж болох хамгийн их хэмжээ буюу зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ)-нээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдсон гэж үздэг. Тиймээс шинжилгээний дүнгээс үзэхэд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан дүн харагдахгүй байна.

### Хүснэгт 15. Шимт хөрсний овоолгын физик-механикийн шинжилгээн дүн

№	Дээж	Чийглэг, %		Хувийн жин, г/см <sup>3</sup>	
		2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Шимт хөрсний овоолго	8.48	6.94	2.57	2.58

Катион солилцооны багтаамжид солилцооны натрийн жингийн хувь нь хар шороо, хар хүрэн, хүрэн хөрс ба саарал хөрсөнд 5%-иас ихгүй хүртэл байна. Шимт хөрсний овоолгын хөрсний физик-механикийн шинжилгээг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-аар MNS 2143:2000 стандартаар тодорхойлуулав.

#### 4.1. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11-д “биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ” гэж тодорхойлсон.

Мөн хуулийн 8.4.6-д “газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ” хэрэгжүүлэх, 9.6-д “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна” гэж тус тус заасныг үндэслэн манай компани 2024 оны нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу 15.000 мод суулгахар төлөвлөсөн.

Уг ажлын хүрээнд Төв аймгийн Жаргалант сумын Эрдэнэтолгой ууланд 12.000 / *Pinus silvestris* /ширхэг нарсны 2-3 настай суулгац, уурхайн бүсэд 1.000 ширхэг улиас / *Ulmus pumila* /, сумын төвийн ногоон байгууламжинд 1.000 ширхэг улиас / *Ulmus pumila* /, 250 ширхэг голтбор / *Lilac* /, 250 ширхэг монос / *Padus asiatica* /, 250 ширхэг гүйлс / *Armeniaca sibirica* /, 250 ширхэг агч /*Acer palmatum*/ амжилттай тариалсан.





Зураг 26. Нарсны суулгац тарихын өмнөх бэлтгэл ажил



Зураг 27. Шан татсан байдал





Зураг 28. Мод тарьж буй байдал



Зураг 29. “Тэн Хун” ХХК-ны бяцхан ой хамгаалагч





Зураг 30. Мод тарихад оролцсон ажилтан, албан хаагчид



Зураг 31. Уурхайн хашаанд мод тарьж буй байдал

4.2. 2012-2024 оны хооронд тарьсан модны тайлан

2012-2024 оны хооронд Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах Нарантолгойн уурхайн байгаль орчин, дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд тарьсан модны тайланг холбогдох байгууллагын албан тушаалтанд тайлагнав.

2010 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласан.

Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсанаар мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүхийн санаачлагаар “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгын дор “Тэн Хун” ХХК нь нэгдэж идэвхи санаачлагатай оролцоор ирсэн билээ.

Хүснэгт 16. 2012-2024 оноос хүртэл тарьсан модны тайлан

№	Name of Latin	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Total
1	<i>Larix sibirica</i>	0	0	16100	0	0	0	0	0	0	0	0	0	0	16100
2	<i>Caragana arborescens</i>	0	0	0	315	100	0	0	0	0	0	0	10000	0	10415
3	<i>Pinus silvestris</i>	50	0	0	0	0	12000	12500	0	5000	0	0	5000	12000	46550
4	<i>Lilac</i>	0	0	0	0	10	0	0	0	0	710	0	0	250	970
5	<i>Hippophae rhamnoides</i>	333	0	0	200	0	0	0	0	0	0	0	0	0	533
6	<i>Rosa acicularis</i>	0	0	0	0	10	0	0	0	0	0	220	0	0	230
7	<i>Ulmus pumila</i>	0	0	0	0	0	0	5000	0	0	0	3780	0	2000	10780
8	<i>Rives diacantia</i>	0	0	0	0	10	0	0	0	0	0	0	0	0	10
9	<i>Populus laurifolia</i>	250	0	0	150	0	0	0	0	0	0	6000	0	0	6400
10	<i>Padus asiatica</i>	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	250	250
11	<i>Armeniaca sibirica</i>	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	250	250
12	<i>Acer palmatum</i>	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	250	250
	Total	633	0	16100	665	130	12000	17500	0	5000	710	10000	15000	15000	92738





Зураг 32. Төв аймгийн БОАЖГ-ын шалгалт



Зураг 33. Эрдэнэтолгой ууланд ойжуулах ажлын шалгалтын явц

2012.05.14 өдөр бүх нийтийн мод тарих өдөр Нарантолгойн уурхайн бүсэд 231 ш чацаргана, 250 ш улиас, 50 ш нарс Жаргалант сумын төвд 120 ш шар хуайсыг суулгаж, нийт 651 ш суулгацыг суулгасан байна.

2014 онд “Ойн Судалгаа Хөгжлийн Төв” УТҮГ-с томилогдсон 2014 оны ойжуулалтын ажлыг шалгаж хүлээн авах комисс Жаргалант сумын нутаг Зүрхэн дэвсэг, Нарантолгойн зүүн энгэр 2 хэсэг газрын тус бүр 5 га нийт 10 га талбайд 2014 оны 05 сарын 15-наас 05 сарын 28-ны өдөр 2-3 настай Сибирь Шинэс /Larix sibirica/ тарьцаар, хуучин ойжуулалтын шан дотор гар аргаар ойжуулах ажлыг гүйцэтгэсэн.

Нэг га талбайд /тарьц суулгацын тоо, үрийн жин хэмжээ/ 2000 хэмжээгээр анх тарьж суулгаснаас хойш 2014 оны 09 дугаар сарын 12-ны өдөр, намрын тооллогоор 1 га-д 1610 ширхэг, нийт талбайд 16.100 ширхэг таримал ургасан. Тарималын жилийн өсөлт 4-6 см, ерөнхий байдал хэвийн, амьдралын хувь 82 байв.

2015 онд 05 дугаар болон 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гаригт Нарантолгойн уурхайн бүсэд 200 ш чацаргана, 315 ш шар хуайс, 150 ш улиас Жаргалант сумын төвд мод тарих ажлыг сумын захиргаатай хамтран 100 ш чацаргана, 100 ш улиас, 200 ш шар хуайс нийт 665 ш суулгацыг суулгасан байна.

2016 оны 05 дугаар 14 өдөр Нарантолгойн уурхайн бүсэд 100 ш шар хуайс, 10 ш нохойн хошуу, 10 ш тэхийн шээг, 10 ш голт бор зэрэг суулгацыг нийт хэлтсүүд, гэрээт компаниудад хуваарийн дагуу нийт 130 ш суулгацыг суулгасан байна.

2017 онд Төв аймгийн Жаргалант сумын Халзан Моностойн, Нэвсээний ар газарт 6 га талбайд 2017.10.14-ний өдөр 2-3 настай нарсны тарьцаар хуучин ойжуулалтын шан дотор гар аргаар ойжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нэг га талбайд 2.000 хэмжээгээр тооцсон болно. Нийт 12.000 ш тарьцыг суулгаж хүлээлгэн өгсөн.

2018 онд Төв аймгийн Жаргалант суманд байрлах Нэвсээний ам гэдэг газар 5 га газарт ойжуулалт хийн Төв аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон комисст хүлээлгэн өгсөн. “Их Тайга” ХХК-иас 3 настай 12.500 ш нарсны суулгацыг суулгасан байна. Уурхайн талбайд 50 сот газарт 5.000 ш хайлаас тарьсан байна. 2020 оны 10 дугаар сарын 17-нд Төв аймгийн Жаргалант сумын Японы амны зүрхний урд өвөрт 2.5 га талбайд нарс модны 2-3 настай 5.000 ш суулгацыг байгууллагын ажилчид, Жаргалант сумын 150 гаруй төрийн албан хаагчдын хамт тарьсан байна.

2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр “Тэн Хун” ХХК-ны ажилчид 122 өрх, төсөвт 5-н байгууллага, нийтийн эзэмшлийн зат талбайд Голт Бор 6 настай 710 ш суулгацыг суулгасан байна.

2022 оны 05 дугаар сарын 16, 17-ний өдрүүдэд нийт 5.000 ш модыг тарьсан. Үүнд: 1000 ш улиас, 220 ш нохойн хошуу, 3.780 ш хайлаасны суулгацыг суулгасан байна. 2022 оны 10-р сарын 05, 06-ны өдрүүдэд 5000 ш тарьж 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 10.000 ш суулгацыг суулгасан байна.



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН-2024

2023 онд Төв аймгийн Эрдэнэтолгойн ууланд 5.000 ш нарсны суулгацыг, Жаргалант сумын ногоон байгууламжинд 10.000 ш шар хуайсны суулгацыг суулгасан байна.

2024 оны 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гариг буюу 2024.10.12-ны өдөр Төв аймгийн Жаргалант сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Тэн Хун” ХХК-ны Нарантолгой алтны уурхайн БОХАБ-ын хэлтсийн ажилтан болон бус хэлтсийн нийт 30 ажилтан албан хаагчид Төв аймгийн Жаргалант сумын Эрдэнэтолгой ууланд 12.000 ширхэг нарсны суулгацийг амжилттай суулгац дууслаа.



2024.10.13-ны өдөр Нарантолгой уурхайн бүсэд 1.000 ширхэг улиасыг амжилттай суулгаж өндөрлөлөө.

Жаргалант сумын цэцэрлэг хүрээлэнд 1.000 ширхэг улиас, 250 ширхэг голт бор, 250 ширхэг монос, 250 ширхэг гүйлс, 250 ширхэг агч нийт 2.000 ширхэгийг хүлээлгэн өгөв.

Ийнхүү 2024 оны намрын мод тарих ажлын хүрээнд нийт 15.000 ширхэг тарьц суулгацыг амжилттай суулгаж сум, орон нутагт хүлээлгэн өгөв.

### Хүснэгт 17. Тарьсан модны мэдээлэл

№	Латин нэр	Тоо, ширхэг	Тарьсан байршил
1	Нарс / <i>Pinus silvestris</i> /	12,000	Эрдэнэтолгой уул
2	Улиас / <i>Populus laurifolia</i> /	1,000	Уурхайн хашаанд
3	Улиас / <i>Populus laurifolia</i> /	1,000	Сумын цэцэрлэгт хүрээлэн
4	Голт бор / <i>lilac</i> /	250	Сумын цэцэрлэгт хүрээлэн
5	Монос / <i>Padus asiatica</i> /	250	Сумын цэцэрлэгт хүрээлэн
6	Гүйлс / <i>Armeniaca sibirica</i> /	250	Сумын цэцэрлэгт хүрээлэн
7	Агч / <i>Acer palmatum</i> /	250	Сумын цэцэрлэгт хүрээлэн
<b>Нийт</b>		<b>15,000</b>	<b>Нийт 25.000.000 сая төгрөг</b>



#### 4.3. Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

Шимт хөрсийг тухайн ордыг ашиглах ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгаснаар тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгаж, бусад газар шорооны ажлын үед холбогдох төсөл баримт бичигт зааснаар хуулж тараах буюу хадгална.

Шимт хөрсний овоолгийг засаж тэгшилэн, хуурайшилттай улиралд усалгаажилтыг тогтмол хийсэн хавар ургамал ургах үед шимт хөрсний зэрлэгийг түүж хэлбэржүүлсэн. Засаж хэлбэржүүлсэн шимт хөрсний овоолго дээрээ дараа жил олон наст ургамлын үрийг цацаж шимт хөрс хийсч үржил шим алдагдахаас сэргийлэх арга хэмжээг авахаар төлөвлөж байна.

#### 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

#### 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд уулын өрөмдлөгийн ажил төлөвлөхөөс өмнө археологийн хүрээлэн болон палентологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд хайгуулын ажлын үед ямар нэгэн дурсгалт зүйл байхгүй байсан. Эдгээр ашиглалтын жилүүдэд нэмэлтээр хайгуулын ажил явагдаагүй учир түүх соёлын дурсгалт зүйл шинээр илэрээгүй болно. Хэрэв талбай орчим тааралдах дурсгалт зүйл олдсон тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдээлэлийг хүргэнэ. Мөн нийт ажилчдад хамгаалах талаар зөвлөмж заавар өгч ажиллана.

#### 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол эрдсэлийг бууруулах талаас дараах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүллээ. Үүнд:

##### 7.1. Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ зарцуулалт

###### 7.1.1. Химийн бодисын хадгалалт

“Тэн Хун” ХХК нь MNS 6488:2014 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” ерөнхий шаардлага стандартын дагуу химийн бодисын агуулахыг барьсан. Тус байгууламж нь Нарантолгойн уурхайн алтны хүдэр боловсруулах үйлдвэрийн зүүн урд талд 270 метр стандартын зайд цианид натрийн төв агуулах байрладаг.

Цианид натрийн агуулах нь 22 тн 11 ширхэг контейнерээс бүрдэнэ. Контейнер тус бүр нь 2 цоож болон лацтай. 24 цагын турш хяналтын 2 камер, хөдөлгөөн мэдрэгч дохиололтой, харуул хамгаалалтын байнгын нэг хамгаалагч хяналт тавин ажилладаг.

Цианит натрийг Нарантолгойн алтны уурхайн баяжуулах үйлдвэрт дараах зориулалттай хэрэглэнэ. Үүнд:

1. Нунтагласан хүдрээс алтыг уусгах
2. Алт ууссан уусмалаас алтыг ялган авахад тус тус хэрэглэнэ.

Үйл ажиллагааны явцад цианитын хэрэглээг хянах, орчныг хордуулахгүй байлгах, хаягдлыг саармагжуулах ажлуудыг хатуу хяналтан дор явуулахад анхаарлаа хандуулан ажиллаж байна. Химийн бодисыг тусад нь хадгалах ба бусад бодистой урвалд орохгүй газар тавина. Агуулахад орж гарах тохиолдол бүрт зайлшгүй бүртгэл хөтлөж, авч гарсан химийн бодисыг ил задгай газар тавихыг хатуу хориглосон.

### 7.1.2. Химийн бодисын тээвэрлэлт

Аюултай бараа гэдэгт хүн, байгаль орчин ба эд хөрөнгөд бодитой аюул учруулж болох шатамхай, тэсрэмтгий, исэлдүүлэгч, зэврүүлэгч зэрэг химийн бодис болон эд зүйлсийг хамруулж авч үздэг.

“Тэн Хун” ХХК нь НҮБ 2020 оны аргачлал, Монгол улсын химийн бодисын тухай хууль, Монгол улсын химийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS 4978:2000 стандарт дагуу болон Монгол улсын Иргэнийн хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн “Түмэн эгшиг” ХХК-ны дахин боловсруулах эко үйлдвэртэй 2023 оны 12 дугаар сарын 27-ны химийн бодисын аюултай хог хаягдал шилжүүлэх №12/068 тоот гэрээний нэмэлт хавсралтаар химийн бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэсэн.

Мөн аюулгүй ачаа тээвэрлэх эрх бүхий Монгол улсын мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй ажилчдаар химийн хортой, аюултай бодичын тээвэрлэлтийг хийж байна.

Химийн бодисын хайрцаг, сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгсэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй, тухайн бодис уурхайн талбарт ашиглах зөвшөөрөл аваагүй, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ байхгүй зэрэг тохиолдлуудад тээвэрлэлт хийхийг хориглодог.

Хүнд даацын 20-30 тонн Nord benz DAP машинаар “Тэн Хун” ХХК-ны Төв аймгийн Жаргалант сумын 3-р багын байршлаас хог хаягдлыг тээвэрлэн Төв аймгийн Сэргэлэн сум 4-зөрлөг нутаг дэвсгэрт оршин “Түмэн Эгшиг” ХХК-ны дахин боловсруулах эко үйлдвэрт хүргэсэн байна.



### 7.1.3. Химийн бодисын хэрэглээ

- ✓ Ус, хөрс, шавар, хаягдлын сан дах цианитын зөвшөөрөгдөх агууламжийн асуудлуудыг мөрдөн ажиллах
- ✓ Цианит хэрэглэх үед битүүмжлэл, агааржуулахыг сайжруулж, хорт бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх
- ✓ Цианит хэрэглэх үедээ хүний биеийг хордуулахаас урьдчилан сэргийлж ажлын хувцас, хормогч, гутал, хошуувч, бээлий зэрэг ажлын тусгай хувцсыг заавал хэрэглэх
- ✓ Баяжуулах үйлдвэрт хорт бодисоос хамгаалах хэрэгсэл болон саармагжуулах тусгай бодисуудыг байрлуулах
- ✓ Цианит уусгах ажиллагаа дууссаны дараа цианитын сав болон гялгар уутыг буцааж агуулахад хүлээлгэн өгөх ба хүлээлцэхдээ акт бүрдүүлж, хэн нэгэн хүн зөвшөөрөлгүй авч явах, хэрэглэхийг хориглох
- ✓ Цианит натрийн уусмалыг зөвхөн мэргэжлийн хүн найруулах ба бусад ажилчид агуулахын байранд орох, хортой бодистой харьцахыг хатуу хориглох
- ✓ Уусгаж, хэмжээг хянасны дараа хадгалах саванд хийж, сайн таглаж, түгжих бөгөөд хүргэх замд асгаж дусаахыг хориглох
- ✓ Цехийн дотор байгаа бүх усыг унданд хэрэглэж болохгүй бөгөөд “Хэрэглэхийг хориглоно” гэсэн мэдээлэх тэмдэг байрлуулж, ундны усны тусгай цэг байгуулах

### 7.1.4. Химийн бодис алдагдсанаас үүсэх нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

Гадаргын болон газрын доорхи усанд химийн бодис алдагдах тохиолдолд тухайн усны эх үүсвэрийг унд ахуйн хэрэгцээндээ ашигладаг хүн амын эрүүл мэнд болон мал, амьтанд сөрөг нөлөөлөл учруулна. Төслийн үйл ажиллагааны явцад химийн хортой, аюултай бодисыг гадаргын болон гүний усанд ямар нэг хэмжээгээр алдагдсан тохиолдолд тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын газарт яаралтай мэдэгдэхийн зэрэгцээ түүнийг ус хангамжийн эх үүсвэр болгон ашиглаж байгаа хүн, малын хэрэглээг хязгаарлах нь зүйтэй бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх, ус хангамжийн шинэ эх үүсвэр бий болгох, нөхөн төлбөр төлөх зэрэг арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

### 7.2. Галын аюулгүй байдал

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрт гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын ажлыг Монгол улсын “Галын аюулгүй байдлын тухайн хууль”, “Аж ахуйн нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй дүрэм”-г мөрдлөг болгон ажилладаг. Уурхай, баяжуулах үйлдвэр, тэсрэх материал болон сэлбэгийн агуулах, шатах тослох материалын агуулах, онцлох тоног төхөөрөмж, хэрэгслийн галын аюулгүй байдлыг хариуцах нь ХАБ хариуцан ажилладаг. Ажлын байранд нарийн дэг журам тогтоож, тамхи татах тусгай байр, галтай ажил, хийн ба цахилгаан гагнуурын ажлыг аюулгүй нөхцлийн дагуу журам боловсруулах хийх, ил задгай гал гаргахгүй байх зарчмыг баримтлан эргүүл жижүүр зохион байгуулж, уурхайн нутаг дэвсгэрийн шатах

тослох, тэсрэх материалын агуулахын орчим хамгаалалтын зурвас байгуулсан. Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, завсар үйлчилгээг цаг тухайд нь хийж, тодорхой арга хэмжээ авч ажиллалаа.

Баяжуулах үйлдвэр, амралтын байрууд, цахилгаан дэд станц, монгол гал тогоо, хятад гал тогоо, тэсрэх материал агуулах, цианидын агуулах, бараа материалын агуулах, шатахуун түгээх дэд станц, оффис зэрэг барилга байгууламжид 3 кг, 5 кг, 35 кг-тай унтаагуур байршуулж нийт 13 галын сарааг будаж өнгө зүсийг сэргээсэн, галын сарааны иж бүрдэлийг 2024 онд шинээр захиалж байршуулсан бөгөөд энэ жил бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллалаа. Мөн өнгөрсөн жил хийгдсэн гал түймрийн аюулаас сэргийлж хуурайшилттай улиралд тэсрэх материалын агуулах, цахилгааны дэд станц, уурхайн гол барилга байгууламжийн эргэн тойрны зэрлэгийг түүж устгах зэрэг арга хэмжээнүүдийг авсан.



Зураг 34. Төв аймгийн Батсүмбэр сумын онцгой байдлын газрын хяналт шалгалт



Зураг 35. Галын аюулгүй байдал, Гамшгийн эрсдлийн сургалт



Зураг 36. Практик сургалт





Зураг 37. Галын сарааны өнгө үзэмж, бүрэн бүтэн байдлыг сэргээн засварлав



Зураг 38. Галын сарааны будгийн ажил

### 7.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал

Уул уурхайн үйлдвэрийн тогтвортой, найдвартай ажиллах гол үнэт баялаг бол ажиллагсад, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хүн. Тиймээс ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлд нэн түрүүнд –Хөдөлмөрийн аюулгүй байдал” гэсэн суурь зарчим хэрэгжих явдал юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зорилго нь ажил олгогч, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны аюулгүй ажиллах арга барилд сургах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгон, осол эндэгдэлгүй, эрүүл ажиллах соёл, зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

“Тэн Хун” ХХК нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н сургалт сургалт зохион байгуулах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын хүрээнд БОХАБЭА-н хэлтэс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгууллаа.

Монгол улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 сарын 09-ны өдрийн дугаар А/36 тушаалын дагуу Төв аймгийн Жаргалант сумын нутагт орших “Тэн Хун” ХХК-ны Нарантолгой уурхай Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу 2024 оны 04-р сарын 10-ны өдрөөс 05-р сарын 10-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа.

1. Нарантолгойн уурхай нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас 2024 онд дэвшүүлсэн “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриан дор сарын аяныг зохион байгуулах тухай удирдлагын шийдвэр гаргаж, холбогдох зардал болох 3,562,500 төгрөгийг төсөвлөж
2. Уриатай уялдуулан нийт ажилтны хамруулсан сарын аяныг зохион байгуулж, үр дүнтэй хэмжихүйц арга хэмжээний төлөвлөгө баталж хэрэгжүүлсэн
3. Сарын аянд удирдлагын манлайллыг хангаж, ажилтан бүрийг оролцуулан, мэдлэг хандлага, соёлыг төлөвшүүлэх чиглэлэр хамтран ажилласан

#### Галын аюулгүй байдал, Гамшгийн эрсдлийн сургалт

2024 оны 04-р сарын 20-ны өдөр “Галын аюулгүй байдал”, “Гамшгийн эрсдлийн” сургалтыг НОБГ-ын ахмад Н. Гансүх удирдан амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Уг сургалтанд бусдыгаа манлайлан идэвхитэй оролцсон П. Үүрцайх мастериин 4-р ээлжийн оператор Л. Лхагвабазар, оператор С. Лхагвадорж, эрүүл ахуйч Б. Отгонжаргал нарыг тус тус 50,000 төгрөгөөр урамшуулсан.





Зураг 39. Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад амжилттай оролцсон ажилтнууд

Хор саармагжуулах бүтээгдэхүүн

Аяны хүрээнд нийт ажилчдыг хамруулж 4-н ээлжинд 2 удаагийн давтамжтай 750 ш сүү, сүүн бүтээгдэхүүнийг олгов.







Зураг 40. Саармагжуулах бүтээгдэхүүн

ХАБ-н сайн сахиагч ажилтан

Аюул ослыг хэн сайн таньж илрүүлж, засаж залруулж, өөрийгөө болон бусдыг аюулаас хэрхэн хамгаалах ХАБ-н 6-н сайн сахиагч ажилтан тус тус 100,000 төгрөгөөр урамшуулав.



Зураг 41. ХАБ сайн сахиагч ажилчид



Витаминжуулах аян-2024

2024 оны 04-р сарын 10-наас 04-р сарын 18-ны хооронд 210 ажилтан бүрийн дархлааг дэмжих зорилгоор витаминжуулах аяныг зохион байгуулсан.



Зураг 42. Витаминжуулалтын аян

АХА-асуулт хариултын тэмцээн

Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе уриан дор бүх ажилтны дунд ХАБ-ын мэдлэг шалгах АХА- асуулт хариултын тэнцээг 4 ээлжний бусад ИТА-ын дунд зохион байгуулсан.



Зураг 43. ХАБ-ын мэдлэг шалгах АХА тэмцээн





Зураг 44. Намрын галын аюулгүй байдлын сургалт



Зураг 45. Намрын галын аюулгүй байдлын практик сургалт



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН-2024

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 2 дах заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолын 3.1.7 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ыг нэгдүгээр, “Хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”, “Ажил, мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн хуудас”, “Эрүүл мэндийн үзлэгийн тайланд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-ын дагуу 2024 оны 11 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэгт байрлах UBLAB лаборатори эмнэлэгтэй хамтран “Уурхайн эмнэлэг” дээр хийгдэж компанийн ажилчид идэвхитэй оролцсон.

№	Үзлэг оношилгооны нэр төрөл	Хүний тоо	Төлбөр
<b>Лабораторийн шинжилгээ</b>			180.000
1	Цусны ерөнхий шинжилгээ /21 үзүүлэлт/		
2	Элэг, цөс /Алат, Асат, Альбумин/		
3	Бөөрний үйл ажиллагаа /Креатинин/		
4	Дотоод шүүрэл /сахар/		
5	Нойр булчирхайн үйл ажиллагаа /амилаза/		
6	Ходоодны шинжилгээ /хелико бактер илрүүлэх/		
7	Өөх тосны солилцоо /ТГ, Холестерин/		
8	Элэгний гепатит /гепатит В, С вирус илрүүлэх/		
9	Серологийн шинжилгээ /ДОХ, Тэмбүү/		
<b>Багажийн оношилгоо</b>			
1	Цээжний рентген зураг		
2	Хэвлийн хэт авиан оношилгоо /ЭХО/		
3	Зүрхний цахилгаан бичлэг /ЭКГ/		
<b>Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг</b>			
1	Дотор, зүрх судасны эмчийн үзлэг, зөвлөгөө		
2	Чих хамар хоолойн эмчийн үзлэг, зөвлөгөө		
3	Мэдрэлийн эмчийн үзлэг, зөвлөгөө		

## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тэн Хун” ХХК нь Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9 дугаар зүйл, Монгол улсын Татварын тухай хуулийн 7.4.17, Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн болно. Энэхүү хог хаягдал цуглуулах тээвэрлэх гэрээ нь хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах эргүүлэн ашиглах устгах, булах үйлчилгээ хийх тэдгээртэй холбогдох гарах зардлыг төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уурхайн хэмжээнд ахуйн гаралтай, үйлдвэрийн гаралтай гэсэн 2 төрлийн хог хаягдал гарна. Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхин дор, ажилчдын байрнаас зайтай байрлуулсан.

Хог хаягдлын цэгийг байгуулахдаа хатуу, шингэнээр нь ялган хаяж байхаар төлөвлөх бөгөөд ингэхдээ мөн дахин ашиглагдах, эс ашиглагдахаар нь ялгана. Хог хаягдлын менежментийн талаар дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг ажилчдын дунд хэвшүүлэх
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ажилчдад танилцуулах, хуулийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөх
- Хатуу хог хаягдал түр хадгалах цэгийг байршлыг оновчтой төлөвлөж хог хаягдлын график байгуулж тогтоосон хугацаанд зайлуулах
- Хог хаягдлын савны тоог олшруулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээ хийж байгуулах
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
- Ахуйн болон аюултай хог хаягдлын бүртгэл хөтөлж, тайланг холбогдох албан тушаалтанд тогтоосон хугацаанд хүргүүлж байх

### Аюултай хог хаягдлын менежмент

- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу аюултай хог хаягдал хадгалах байртай болох, аюултай хог хаягдлыг бүртгэх, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах арга хэмжээ авах
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлд заасны дагуу аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэх, аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг тус

хуулийн 8.1.4-г заасан зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхэд мөн хуулийн 8.1.7а-д заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх.

- Шатах тослох материалын хаягдлыг орчиндоо сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг хангаж хадгалах
- Ахуйн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгаж зайлуулах, дахин ашиглагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10.3-д заасан үйл ажиллагаануудыг хориглох, мөрдөж ажиллах
- Уурхайн үйл ажиллагаанаас гарах ажилласан тос, масло, химийн бодисын сав, тосны алчуурууд, будаг, аккумулятор, хаягдал дугуй зэрэг хог хаягдал гарах ба эдгээрээс автотransпортын аккумулятор, хаягдал дугуйг дахин боловсруулах үйлдвэрт тушаах
- Ажилласан тос маслог дахин боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан нийлүүлэх

#### Үйлдвэрийн гаралтай хог хаягдал

- Үйлдвэрийн гаралтай хог хаягдал, уурхайн үйл ажиллагаанаас гарах ажилласан тос, масло, химийн бодисын сав, тосны алчуурууд, будаг аккумулятор, хаягдал дугуй зэрэг хог хаягдал гарна.



Зураг 46. Хог ангиалан ялгаж буй байдал





Зураг 47. Ажилчдад хог ангиалан ялгах талаар зөвлөгөө өгч буй байдал



Зураг 48. Ангиалан ялгах хогийн сав байршуулсан байдал



### 8.1. Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах

“Тэн Хун” ХХК нь тайлант онд БОХАБЭАХ-ээс зохион байгуулсан хавар, намрын 2 удаагийн их цэвэрлэгээнд компанийн холбогдох удирдлагууд болон хэлтсүүдийн дарга нар энэхүү цэвэрлэгээнд идэвхитэй оролцсон.



Зураг 49. Орчны хог орчны цэвэрлэгээ



Зураг 50. Орчны хог орчны цэвэрлэгээний өмнөх ба дараах байдал





Зураг 51. Салдагаас уурхай хүртэлх замын цэвэрлэгээ



Зураг 52. Хог хаягдлын цэвэрлэгээний өдөр


Уурхайн орчны хог хаягдлын цэвэрлэгээний бүсчлэлийг баяжуулах үйлдвэр, авто бааз, ажилчдын хотхоноос хамгаалалтын байр хүртэл гэсэн 8 хэсэгт хувааж тус бүрт нь хэсэгчлэн хувааж зураглал үйлдсэн. Орчны хог хаягдлын цэвэрлэгээний нэгдсэн бүсчлэлийн зурагтай болсоноор төлөвлөгөөт их цэвэрлэгээнүүдийг хэлтэс, нэгжүүдэд хувиарлан өгч цэвэрлэгээг үр дүнтэй зохион байгуулахад чухал ач холбогдолтой ажил болсон.



## 8.2. Хог хаягдлын цэвэрлэгээний бүсчлэлийн зураг боловсруулах

“Хог хаягдлын тухай” хуулийн 9.2-т заасны дагуу ААНБ нь хог хаягдлаа тусгайлан бэлдсэн цэгт төвлөрүүлсэн, орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах бөгөөд өөрийн эзэмшлийн талбайд тогтмол хугацаанд хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулдаг.

Мөн ААНБ-ын ажилтан бүр “Хог хаягдлын тухай” хуулийн 9.3-д заасны дагуу Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй. Иймд дээрх хуулийн заалтыг үндэслэн энэ хавар, намрын уурхайн цэвэрлэгээний ажлыг тус тус зохион байгуулсан.



Зураг 53. Орчны хог хаягдлын бүсчлэлийн зураг

### **8.3. Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулах**

Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хуулийн Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчин аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн Аюулгүй хог хаягдлыг тээвэрлэх, Аюултай хог хаягдлыг шилжүүлэх гэрээг “Түмэн Эгшиг” ХХК-тай байгуулсан.

2023 оны 12-р сарын 27-ний өдрийн №12/068 тоот аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний үргэлжлэх хугацаа нь 2013 оны 12-р сарын 27-ний өдрөөс 2025 оны 12-р сарын 27-ний өдрийг хүртэл 2 /хоёр/ жилийн хугацаатай гэрээ байгуулсан.

2023 оын 12-р сарын 27-ний өдрийн №2023/50 тоот аюултай хог, хаягдал тээвэрлэлтийн гэрээний үргэлжлэх хугацаа нь 2023 оны 12-р сарын 27-ний өдрөөс 2025 оны 12-р сарын 27-ний өдрийг хүртэл 2 /хоёр/ жилийн хугацаатай гэрээг тус тус байгуулсан.

### **8.4. Хог хаягдал цуглуулах тээвэрлэх гэрээ**

Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9 дугаар зүйл, Монгол улсын Татварын тухай хуулийн 7.4.17, Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн 2024.01.01-ээс 2025.01.01-нийг хүртэл хог хаягдал цуглуулах тээвэрлэх гэрээг Төв аймгийн Жаргалант сумын Байгаль хамгаалагч С. Нямдоржтой байгуулсан болно.

## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 11-р сарын 01-нд Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг 3-р багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулсан. Байгаль орчны менежментийн тайлангийн биелэлтийн хэлэлцүүлсэн байдлыг зургаар болон бичгээр хавсаргав.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэцүүлэг	Тайланг танилцуулах хэлбэр	Тайлангийн агуулга	Хугацааны тов	Хэрэгжүүлэгч	Хэлэлцүүлэгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сумын ИТХ-д 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Багийн Иргэдийн хуралд илтгэл тавьж танилцуулна. Уулзалт хийнэ.	Тухайн жилийн БОМТ-ийн хяналт гүйцэтгэлийг тайлагнах	11-р сарын 1-ны дотор	“Тэн Хун” ХХК	Аман болон бичиг хэлбэрээр	Жаргалант суманд
Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт	Хэвлэмэл хэлбэрээр 3 хувь		11-р сарын 1-нд		-	-
Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ХБОБНУГ-т	Хэвлэмэл хэлбэрээр 3 хувь		12-р сарын 1-ны дотор		-	-

“Тэн Хун” ХХК-ийн 2024 оны Байгаль орчны менежментын төлөвлөгөөний дагуух ажилуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн мөн сум орон нутагт оруулж байгаа хандив, дэмжлэг тусламж “Тэн Хун” ХХК-ийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга тайланг тавьлаа.

Мөн иргэдийн асуултанд хариулж иргэдээс санал хүсэлтийг аман байдлаар авч тэмдэглэж авсан бөгөөд иргэдээс ирсэн санал хүсэлт асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч түүнийгээ дараа дараагийн багийн хурлаар тайлагнахаар шийдвэрлэлээ.





Зураг 54. БОМТБТ-г сумын ИТХ-ын танилцуулах үеийн зураг

## 10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь байгаль орчны менежментийн хэрэгжилтийн баталгааг бий болгож буй хэлбэр гэж үзэж ихээхэн ач холбогдол өгөх ёстой. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус бусад алба, хэлтэсийн ажилтнууд болоод гэрээт ажилтан, албан хаагч нарын оролцоо шаардагддаг.

Тус төлөвлөгөөгөөр байгаль орчны менежментийн хэрэгжилтид оролцооны хэлбэрийг тодорхойлон хэрэгжилтийг хангах зорилтуудыг дэвшүүлж ажиллаж байна.

2024 оны хувьд манай байгууллагын удирдлагуудын зүгээс хуулийн хүрээнд зайлшгүй шаардлагатай байдаг баримт бичгүүдийг мэргэжлийн байгууллагаар батлуулж хийлгүүлэн ажилласан. Тухайлбал:

- Байгаль орчны аудитын тайланг “Мон Газар Консалтинг” ХХК-иар хийлгэж батлуулсан.
- 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж мөрдөж ажилласан.
- Орчны хяналт шинжилгээг “Их Зос” ХХК-тай хамтын гэрээ байгуулж зөвлөгөөний дагуу ажлуудыг хэрэгжүүлсэн.
- Газар эзэмших эрхийн захирамжыг Төв аймгийн Жаргалант сумын засаг даргаар батлуулж хуулийн хүрээний үйл ажиллагааг явуулж байна.
- Газар ашиглах гэрээ байгуулж төлбөрийг барагдуулсан.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газартай ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг байгуулж усыг зөв зохистой гэрээний дагуу хяналтыг тавин үйл ажиллагаа явуулж байна.
- Ус бохирдуулсан төлбөрийн тухай хуулийн дагуу улирал бүр бохир усны шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж бохир усны төлбөрийг тооцуулсан.

### 10.1. Үүрэг хариуцлага

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрээс хамааруулан гаргасан. Төслийн хүчин чадлыг эзэмших, түүнд хүрэхийг зорих хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн болно. Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг уурхайн үйл ажиллагаа хариуцсан хэлтсийн дарга удирдан явуулна.

Уурхайн ажилчдын тодорхой хэсгийг Төв аймгийн Жаргалант сумаас авч ажиллуулдаг. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах нь манай төслийн бас нэгэн зорилго билээ. Төслийн хугацаанд уурхайн удирдлагын зохион байгуулалт, бүтэц бүрэлдэхүүн хэвээр байх бөгөөд уурхайн дотоод зохион байгуулалт, төлөвлөгөө шалтгаанаас хамаарч уурхайн хүчин чадалд огцом өөрчлөлт гарах тохиолдолд ажлын байрны орон тоо нэмэгдэж, хасагдаж болно.


Төсөл хэрэгжих хугацаанд боломжит ханган нийлүүлэлтийг орон нутгаас авахаар тооцож байгаа бөгөөд энэ нь орон нутгийн хувиараа аж ахуй эрхлэгчид болон малчдыг дэмжих тодорхой хэмжээний дэмжлэг болно гэж үзэж байна.

Уурхай нь хоногт 12 цагийн 2 ээлжээр тасралтгүй ажиллах ба ажилчид 14 хоног ажиллаж, 14 хоног амрах системээр ажиллана.


Орон нутгаас авсан ажилчдыг мэргэжлийн сургалтанд хамруулах ба уурхайн нийт ажилчдыг байнгийн сургалт семинарт оролцуулна. Мөн уурхайн ажилчдын эрүүл ахуйг хангах үүднээс эмч ажиллах бөгөөд тогтмол үзлэг хийж, шаардлагатай аваар осол гарсан нөхцөлд шуурхай ажиллана.

Байгууллагын байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дараах 7-н хэлтэсүүдийн үйл ажиллагаагаар ханган ажиллаж байна. Үүнд:

1. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс



2. Хүний нөөц захиргаа удирдлагын хэлтэс
3. Баяжуулах үйлдвэрийн хэлтэс
4. Тоног төхөөрөмж засвар үйлчилгээний хэлтэс
5. Үйлдвэр төлөвлөлтийн хэлтэс /далд уурхайн үйл ажиллагааг хариуцан, хяналт тавих/
6. Хадгалалт, түгээлтийн хэлтэс
7. Автобаазын хэлтэс хамтран 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд оролцсон билээ.



Диаграмм 2. Хэсгүүдийн харьцаа



## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

### 11.1. Хөрсөн бүрхэвчийн мониторинг

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг төлөвлөгөөнд хөрсний хяналтын цэгүүдээс дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэхээр тусгасан байдаг. Үүний дагуу ШУА, Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн хөрс судлалын лаборатори болон “Алс” ХХК итгэмжлэгдсэн лабораториудад дараах үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан.


#### Хүснэгт 18. Хөрсний дээжинд задлан шинжилгээ хийсэн арга, нарийвчлал

№	Үзүүлэлт	Аргазүй	Стандарт
1.	Дээж бэлтгэх, хатаах	Хуурай аргын нөхцөлд	ISO11464:2006 Soil quality-Pretreatment of samples for physical-chemical
2.	Дээж шигших	2 мм	
3.	pH	Хөрс:ус (1:2.5), pH метр	pH-ыг тодорхойлох MNS ISO 10390-2001
4.	CaCO <sub>3</sub>	Кальциметр, эзэлхүүний	Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
5.	Цахилгаан дамжуулах чадвар	Хөрс:ус (1:2.5), ЕС метр	
6.	Органик агууламж	Тюрины, Бихроматын исэлдэлт	
7.	Хөдөлгөөнт Фосфор, Кали	Мачигины арга	
8.	Механик бүрэлдэхүүн (элс-2-0.05мм, тоос 0.05-0.002мм, шавар <0.002 мм)	Пипеткийн арга	ISO11277:2009 Soil quality-Determination of particle size distribution in mineral soil material-Method by sieving and sedimentation

**Хүснэгт 19. Хөрсний зүсэлтийн цэгүүдийн бичиглэлийн мэдээлэл**

№	Байршил	Хүдэр тээвэрлэдэг төв замын урд	Баяжуулах үйлдвэрийн зүүн урд	Хаягдлын далангийн доод талд	Уурхайн хашааны гадна талын атар газар	Герман амны доод талд	Герман ам
1.	Өргөрөг	48°33'59"	48°34'01"	48°34'6"	48°34'01.0	48°34'40.4"	48°34'33"
2.	Уртраг	105°55'38"	105°55'36"	105°55'23"	105°55'07.6"	105°56'09.7"	105°55'59"
3.	Өндөр	1090	1100	1100	1109	1068	1080
4.	Гадарга	Уулын бэл, хажуу	Уулын бэл, хажуу	Уулын бэл, хажуу	-	-	Хажуугийн дунд
5.	Бичил гадарга	Налуу	Тэгшивтэр	Уулын бэл хажуу	Хажуугийн дунд	Уулын хөндий	Налуу
6.	Гадаргын налуу	8-15	3-5	8-15	8-15	3-5	8-15
7.	Зүг зовхис	Зүүн хойд	Зүүн урд	Баруун урд	Баруун	Зүүн хойд	Зүүн хойд
8.	Хөрсний эвдрэл	Техникийн нөлөөгөөр хөрсний гадарга нь эвдрэлд орсон	Гадаргад маш нарийн тоосорхог хэсэг хуримтлагдсан	Гадаргад маш нарийн тоосорхог хэсэг хуримтлагдсан	Техникийн нөлөөгөөр ойр орчмын хөрсний гадарга эвдрэлд орсон	-	-
9.	Гадаргын чулуу	0-5%	10-15%	5-10%	0-5%	10-20%	Чулуугүй
